



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 25 (550)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Онц байдал тогтоох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм, сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2008 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2008 оны долдугаар сарын 3

№25 (550)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

362. Онц байдал тогтоох тухай Дугаар 194 709

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

363. Онц байдал тогтоох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг батлах тухай Дугаар 52 710

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

364. Тооны дээд хязгаар тогтоох тухай Дугаар 94 710

365. Ерөнхий консулыг эгүүлэн татах тухай Дугаар 100 711

366. Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай Дугаар 101 711

367. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Дугаар 103 712

368. Журам батлах тухай Дугаар 109 714

369. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд тусласан сангийн дүрэм, сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай Дугаар 110 733

370. Үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай Дугаар 111 736

371. 2008 онд хувьчлах хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай Дугаар 112 740

372. Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч ажиллуулах тухай Дугаар 113 740

373. Ажлаас чөлөөлөх тухай Дугаар 115 742

374. Ажилд түр томилох тухай Дугаар 116 742

375. Журам шинэчлэн батлах тухай Дугаар 120 742

376. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Дугаар 124 748

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

008 оны 07 дугаар
арын 01-ний өдөр

Дугаар 194

Улаанбаатар
хот

Онц байдал тогтоох тухай

2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр ийслэлийн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт үлэг хүмүүсийн хүч хэрэглэсэн хууль бус үйл жиллагааны улмаас нийтийн эмх замбараагүй айдас үүсч, хууль сахиулах байгууллагын жилтнуудад халдан амь насанд нь заналхийлж, д хөрөнгө устгах, галдан шатаах үйл ажиллагаа аамжирч нийтийн эмх замбараагүй байдал бий олсон тул энэхүү онцгой нөхцөл, үр дагаврыг рилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгох эрилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар

зүйлийн 1 дэх хэсгийн 12-т заасан бүрэн эрхийнхээ дагуу, Онц байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3.6 дахь хэсгүүдийг баримтлан нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт 2008 оны 7 дугаар сарын 01-ний 24.00 цагаас эхлэн 4 хоногийн хугацаанд онц байдал зарласугай.

Онц байдлыг зарласан хугацаанд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлсүгэй.

1.Улсын онц чухал болон хүн амын амьжиргааны хангамжийн объектуудыг хүч нэмэгдүүлэн хамгаалах,

2. Хууль тогтоомж зөрчиж, зохион байгуулсан жагсаал, цуглаан, олон нийтийн бусад арга хэмжээг хуульд заасан арга, хүч хэрэгслээр шууд албадан тараах,

3. Улаанбаатар хотын төвийн хэсэгт тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, тэдгээрт үзлэг хийх,

4. Нийтийн эмх замбараагүй байдал бий болгож хүч хэрэглэсэн үйл ажиллагаа явуулсан буюу явуулж байгаа бүлэг хүмүүсийг албадан тараах, албадан саатуулах, тэдгээрийн зэвсэг, техник хэрэгслийг хураан авах,

5. Улаанбаатар хотын төвийн хэсэг /Бага тойруу/-г 22.00 - 08.00 цагийн хооронд хөл хорьж, зөрсөн этгээдийг цагдаа буюу цэргийн эргүүл хөл хорих цаг дуустал, иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиггүй бол хэн болохыг нь тогтоох хүртэл, гэхдээ 72 цагаас илүүгүй хугацаагаар албадан саатуулах.

6. Дуу авиаг чангаруулах техник хэрэгслийн ашиглалтыг хориглох, шаардлагатай бол түр хураан

авах, Үндэсний олон нийтийн радио телевизээс бусад телевизийн үйл ажиллагааг онцгой байдлыг цуцлах хүртэл зогсоох,

7. Соргууруулах ундааны зүйл худалдах, тараахыг хориглох,

8. Иргэдийн эзэмшилд байгаа галт болон хүйтэн зэвсэг, галт хэрэгсэл, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэлийн технологид хэрэглэдэг тасэрч дэлбэрэх, хүчтэй үйлчлэх химийн хорт болон цацраг идэвхт бодис, сургалтын зориулалттай байлдааны зэвсэг, техник хэрэгслийн ашиглалтад хяналт тогтоох,

9. Энэхүү зарлигийг хэрэгжүүлэхэд шаардагдах арга хэмжээг Онц байдлын тухай хууль болон бусад хуулийн хүрээнд холбогдох байгууллагуудын хүч хэрэгслийг дайчлан удирдан зохион байгуулж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд /Ц.Мөнх-Оргил/-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 07 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар
хот

Онц байдал тогтоох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12 дахь заалт, Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Онц байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, санал хураалтын дунг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Онц байдал тогтоох тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 194 дүгээр зарлигийг баталсугай.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдөр буюу 2008 оны 7 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 94

Улаанбаатар
хот

Тооны дээд хязгаар тогтоох тухай

Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2. Цэргийн албыг дүйцүүлэн хаах журмын дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД Ж.БАТХУЯГ

1. 2008 онд цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэний тооны дээд хязгаарыг хавсралтын ёсоор баталсугай.

Засгийн газрын 2008 оны 94 дүгээр
тогтоолын хавсралт

2008 ОНД ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНД ЭЛСҮҮЛЭХ ИРГЭНИЙ ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР

№	Аймаг, нийслэл	Тооны дээд хязгаар
1	Архангай	130
2	Баян-Өлгий	60
3	Баянхонгор	60
4	Булган	30
5	Говь-Алтай	60
6	Говьсүмбэр	10
7	Дархан-Уул	32
8	Дорноговь	35
9	Дорнод	50
10	Дундговь	20
11	Завхан	60
12	Орхон	50
13	Өвөрхангай	50
14	Өмнөговь	40
15	Төв	30
16	Увс	60
17	Сүхбаатар	60
18	Сэлэнгэ	60
19	Ховд	50
20	Хөвсгөл	40
21	Хэнтий	60
22	Улаанбаатар	85
	Бүгд	1132

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 100

Улаанбаатар
хот

Ерөнхий консулыг эгүүлэн татах
тухай

Дипломат албаны тухай хуулийн 16.2-ыг
үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ
нь.

Ерөнхий консул Гомбын Сүхээг эгүүлэн
татсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

Гадаадад ажиллах томилолтын хугацаа нь
дууссантай холбогдуулан Монгол Улсаас
Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа

ГАДААД ХЭРГИЙН
САЙД

С.ОЮУН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 101

Улаанбаатар
хот

Мөнгөн төлбөрийн хэмжээг
тогтоох тухай

Монгол Улсын иргэний цэргийн үүргийн
Болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын
тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг
үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ
нь.

2. Мөнгөн төлбөрийн зарцуулалтад хяналт
тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд
Ж.Батхуяг, Сангийн сайд Ч.Улаан нарт, мөнгөн
төлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу
төлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг,
нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

1. Цэргийн дүйцүүлэх албыг 2008 онд
мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний
төлөх төлбөрийн хэмжээг 1.570.000 (нэг сая таван
зуун далан мянга) төгрөг байхаар тогтоосугай.

БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД

Ж.БАТХУЯГ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 103

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5.4-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

зүйлийн жагсаалт батлах тухай Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 241 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад дор дурдсан агуулга бүхий 275-289 дэх заалт нэмсүгэй.

1. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт

275

Дурсгалын нэр:
Зохиогч:
Бүтээгдсэн он:
Хадгалагдаж буй газар
Дурсгалын шинж байдал:
Хувийн дугаар:

Очирдара
Г.Занабазар
ХҮП зуун
Өвөрхангай, Хархорин сум, Шанхын Баруун хүрээ хийд
Хүрэл цутгамал, алт шармал 34x22x12.5 см, жин 6.040 гр
2008-1-1

276

Дурсгалын нэр:
Зохиогч:
Бүтээгдсэн он:
Хадгалагдаж буй газар
Дурсгалын шинж байдал:
Хувийн дугаар:

Цагаан дара эх
Г.Занабазар
ХҮП зуун
Өвөрхангай, Хархорин сум, Шанхын Баруун хүрээ хийд
Хүрэл цутгамал, алт шармал 24.5x17x11.5 см, жин 3400 гр
2008-1-2

277

Дурсгалын нэр:
Зохиогч:
Бүтээгдсэн он:
Хадгалагдаж буй газар
Дурсгалын шинж байдал:
Хувийн дугаар:

Ногоон дара эх
Нэр үл мэдэгдэх бүтээлч
ХҮП зуун
Өвөрхангай, Хархорин сум, Шанхын Баруун хүрээ хийд
Хүрэл цутгамал, алт шармал 25x18x12.5 см, жин 4200 гр
2008-1-3

278

Дурсгалын нэр:
Зохиогч:
Бүтээгдсэн он:
Хадгалагдаж буй газар
Дурсгалын шинж байдал:

Босоо Майдар
Г.Занабазар
ХҮП зуун
Өвөрхангай, Хархорин сум, Шанхын Баруун хүрээ хийд
Гуулин цутгамал, алт шармал 80.3x20x11 см, жин 19400 гр
Сэнтий 92см x 26см x 26см
2008-1-4

Хувийн дугаар:

279

Дурсгалын нэр:
Зохиогч:
Бүтээгдсэн он:
Хадгалагдаж буй газар
Дурсгалын шинж байдал:
Хувийн дугаар:

Шамбалын орны байгуулалт
Нэр үл мэдэгдэх зураач
ХҮП зуун
Өвөрхангай, Хархорин сум, Шанхын Баруун хүрээ хийд
Шүтээн зураг, Даавуу, шороон будаг, 113x76 см
200-1-5

280

Дурсгалын нэр:

Зохиогч:
Бүтээгдсэн он:
Хадгалагдаж буй газар
Дурсгалын шинж байдал:
Хувийн дугаар:

Дүйнхор-Цогт цагийн хүрдэн бурхны Лагшингийн хот мандлын Зүүн зүгийн бурхад
Нэр үл мэдэгдэх зураач
ХҮП зуун
Өвөрхангай, Хархорин сум, Шанхын Баруун хүрээ хийд
Шүтээн зураг, Даавуу, шороон будаг, 127x85 см
2008-1-6 (1)

- 281
 Дурсгалын нэр: Дүйнхор-Цогт цагийн хүрдэн бурхны Лагшингийн хот мандлын Урд зүгийн бурхад
 Зохиогч: Нэр үл мэдэгдэх зураач
 Бүтээгдсэн он: ХҮП зуун
 Хадгалагдаж буй газар: Өвөрхангай, Хархорин сум, ШанхынБаруун хүрээ хийд
 Дурсгалын шинж байдал: Шүтээн зураг. Даавуу, шороонбудаг, 127x85 см
 Хувийн дугаар: 2008-1-6(2)
- 282
 Дурсгалын нэр: Дүйнхор-Цогт цагийн хүрдэн бурхны Лагшингийн хот мандлын Баруун зүгийн бурхад
 Зохиогч: Нэр үл мэдэгдэх зураач
 Бүтээгдсэн он: ХҮП зуун
 Хадгалагдаж буй газар: Өвөрхангай, Хархорин сум, ШанхынБаруун хүрээ хийд
 Дурсгалын шинж байдал: Шүтээн зураг. Даавуу, шороонбудаг, 127x85 см
 Хувийн дугаар: 2008-1-6(3)
- 283
 Дурсгалын нэр: Дүйнхор-Цогт цагийн хүрдэн бурхны Лагшингийн хот мандлын Хойд зүгийн бурхад
 Зохиогч: Нэр үл мэдэгдэх зураач
 Бүтээгдсэн он: ХҮП зуун
 Хадгалагдаж буй газар: Өвөрхангай, Хархорин сум, ШанхынБаруун хүрээ хийд
 Дурсгалын шинж байдал: Шүтээн зураг. Даавуу, шороонбудаг, 127x85 см
 Хувийн дугаар: 2008-1-6(4)
- 284
 Дурсгалын нэр: Дүйнхор-Цогт цагийн хүрдэн бурхны Зарлигийн хот мандлын бурхад
 Зохиогч: Нэр үл мэдэгдэх зураач
 Бүтээгдсэн он: ХҮП зуун
 Хадгалагдаж буй газар: Өвөрхангай, Хархорин сум, ШанхынБаруун хүрээ хийд
 Дурсгалын шинж байдал: Шүтээн зураг. Даавуу, шороонбудаг, 127x85 см
 Хувийн дугаар: 2008-1-6(5)
- 285
 Дурсгалын нэр: Дүйнхор-Цогт цагийн хүрдэн бурхны Тааллын хот мандлын бурхад
 Зохиогч: Нэр үл мэдэгдэх зураач
 Бүтээгдсэн он: ХҮП зуун
 Хадгалагдаж буй газар: Өвөрхангай, Хархорин сум, ШанхынБаруун хүрээ хийд
 Дурсгалын шинж байдал: Шүтээн зураг. Даавуу, шороонбудаг, 127x85 см
 Хувийн дугаар: 2008-1-6(6)
- 286
 Дурсгалын нэр: Дүйнхор-Цогт цагийн хүрдэн бурхны Дорж шүт сахиус
 Зохиогч: Нэр үл мэдэгдэх зураач
 Бүтээгдсэн он: ХҮП зуун
 Хадгалагдаж буй газар: Өвөрхангай, Хархорин сум, ШанхынБаруун хүрээ хийд
 Дурсгалын шинж байдал: Шүтээн зураг. Даавуу, шороонбудаг, 127x85 см
 Хувийн дугаар: 2008-1-6(7)
- 287
 Дурсгалын нэр: Богд Зонхова
 Зохиогч: Нэр үл мэдэгдэх зураач
 Бүтээгдсэн он: ХҮШ зуун
 Хадгалагдаж буй газар: Өвөрхангай, Хархорин сум, ШанхынБаруун хүрээ хийд
 Дурсгалын шинж байдал: Шүтээн зураг. Даавуу, шороонбудаг, 63x45 см
 Хувийн дугаар: 2008-1-7

288

Дурсгалын нэр:
Зохиогч:
Бүтээгдсэн он:
Хадгалагдаж буй газар
Дурсгалын шинж байдал:

Дархан их бүрээ
Нэр үл мэдэгдэх урлаач
ХҮП зуун
Өвөрхангай, Хархорин сум, ШанхынБаруун хүрээ хийд
Найман тахилтай мөнгөн бөгжтэй, зэс хөөмөл, гурав
сунадаг, хос, урт 260 см, диаметр 20 см
2008-1-8

Хувийн дугаар:

289

Дурсгалын нэр:
Зохиогч:
Бүтээгдсэн он:
Хадгалагдаж буй газар
Дурсгалын шинж байдал:
Хувийн дугаар:

ҮШ Богдын хөрөг
Б.Шарав
1911-1912 он
Өвөрхангай, Хархорин сум, ШанхынБаруун хүрээ хийд
Гэрэл зургийн цаасан дээр шороон будгаар зурсан, 80x53 см
2008-1-9

2. "Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт батлах тухай" Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 241 дүгээр тогтоолоор баталсан 1 дүгээр хавсралтын "дансны дугаар" гэснийг "хувийн дугаар" гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Н.БОЛОРМАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 109

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 6.1-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

ёслолын газар" гэж өөрчилж, "Төрийн ёслолын журам батлах тухай" Засгийн газрын 2000 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 24 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

1. "Төрийн ёслолын журам"-ыг хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Тадаад хэргийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрч, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай" Засгийн газрын 2004 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 248 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн "Ёслолын хэлтэс" гэснийг "Төрийн дипломат

ГАДААД ХЭРГИЙН САЙД

С.ОЮУН

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Н.ЭНХБОЛД

Засгийн газрын 2008 оны 109 дүгээр
тогтоолын хавсралт

ТӨРИЙН ЁСЛОЛЫН ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

байгуулах, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нарыг ёслолын арга хэмжээнд оролцуулах, гадаадын зочин төлөөлөгчидтэй уулзуулах зэрэг үйл ажиллагаа мөн.

1.1. Энэхүү журмын зорилт нь Монгол Улсын Төрийн ёслолын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, тогтсон дэг жаягийн дагуу зохион байгуулахад оршино.

2. Төрийн ёслолын төрөл

1.2. Төрийн ёслол нь Монгол Улсын үндэсний болон дипломат ёслол, нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэх зэрэг ёслол хүндэтгэлийн арга хэмжээг зохион

2.1. Монгол Улсын төрийн ёслол нь үндэсний болон дипломат ёслол гэсэн төрөлтэй байна.



2.2. Монгол Улсын хэмжээнд нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэх, төрийн тэргүүн, Улсын Их Хурлын гишүүн, Үндсэн Хуулийн Цэцийн гишүүн тангараг өргөх, тамга шилжүүлэх, улсын цол, төрийн шагнал, цэргийн дээд цол хүртээх, одон медалиар шагнах, Засгийн газрын хүндэт өргөмжлөл гардуулах, эмгэнэн гашуудах зэрэг төрийн үндэсний ёслолтой холбоотой арга хэмжээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төрийн ёслолын алба /цаашид "Төрийн ёслолын алба" гэх/ зохион байгуулж, эрхлэн гүйцэтгэнэ.

2.3. Итгэмжлэх жуух бичиг барих, хүлээн авах, төрийн айлчлал, албан ёсны айлчлал, ажлын болон хувийн айлчлал хийх, Дипломат төлөөлөгчийн газруудтай харилцах зэрэг Монгол Улсын дипломат ёслолтой холбоотой арга хэмжээг Гадаад хэргийн яамны Төрийн дипломат ёслолын газар /цаашид "Төрийн дипломат ёслолын газар" гэх/ зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

3. Төрийн ёслолын зарчим

3.1. Төрийн ёслол нь түргэн, шуурхай, зардал, чирэгдэл багатай байх.

3.2. Монгол Улсын төрийн үндэсний ёслол нь энэ журмын 3.1-д зааснаас гадна сонгодог ёс, үндэсний уламжлалт ёс заншил, шинэ хандлагыг хослуулан хэрэглэж боловсронгуй болгох.

3.3. Монгол Улсын дипломат ёслол нь энэ журмын 3.1-д зааснаас гадна үндэсний онцлог, ёс заншлыг илэрхийлэхийн хамт олон улсын жишиг, хэм хэмжээнд нийцсэн байх зарчимд тулгуурлана.

4. Төрийн ёслолын ахлал

4.1. Төрийн албан хаагч нь төрийн ёслолын ахлалтай байх бөгөөд ахлалыг төрийн ёслолын үйл ажиллагаанд мөрдөнө.

4.2. Төрийн өндөр албан тушаалтны ёслолын ахлалыг "Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2002 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 73 дугаар тогтоолыг жишиг болгоно.

4.3. Захиргааны болон тусгай албан тушаалтны ёслолын ахлалыг "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 354 дүгээр тогтоолыг жишиг болгоно.

5. Төрийн сүлд байрлуулах, Төрийн далбаа мандуулах, Төрийн дууллыг эгшиглүүлэх

5.1. Төрийн сүлд байрлуулах, Төрийн далбаа мандуулах, Төрийн дуулал эгшиглүүлэхдээ Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийг баримтална.

6. Их цагаан туг-Төрийн тугийг хүндэтгэн дээдлэх

6.1. Их цагаан туг-Төрийн туг /цаашид "Төрийн туг" гэх/-ийг хүндэтгэн дээдлэхэд Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль, "Төрийн тугийг хүндэтгэн залах журам батлах тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1994 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 67 дугаар зарлигийг баримтална.

7. Нийтээр тэмдэглэх баярын өдөр

7.1. Их Монгол Улс байгуулсны болон Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ой /цаашид "Наадам" гэх/-оор төрийн ёслолын дараахь арга хэмжээг зохион байгуулна:

7.1.1. Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлж, Д.Сүхбаатарын хөшөөнд Төрийн ёслолын журмын дагуу цэцэг өргөнө. Хүндэтгэл үзүүлэх, цэцэг өргөхөд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Батлан хамгаалах яам болон бусад яам, Нийслэлийн төр, захиргааны байгууллагын удирдлага, Улаанбаатар хот дахь Дипломат төлөөлөгчийн газруудын тэргүүн нар /хүсэлт, захиалгаар нь/, Улсын Их Хуралд суудалтай улс төрийн намууд, ахмадын байгууллага, иргэдийн төлөөлөгчид оролцоно. Гадаадын зочид төлөөлөгчдийг хүсэлтээр нь оролцуулна;

7.1.2. Хүндэтгэлийн концерт тоглоно. Концертод Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Дипломат төлөөлөгчийн газруудын тэргүүн, гадаадын зочид, төлөөлөгчид, Улсын Их Хуралд суудалтай улс төрийн намуудын дарга, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо /цаашид "Зохион байгуулах хороо" гэх/-ны гишүүд, албаны бусад хүмүүс болон иргэдийн төлөөлөгчид урилгаар оролцоно. Концерт нээхийн өмнө Төрийн дуулал эгшиглүүлнэ;

7.1.3. Тэгш ой тохиосон бол Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан, баярын хурал, ёслолын буудлага хийнэ. Хуралд энэ зүйлийн 7.1.1-7.1.2-т заасан хүмүүс урилгаар оролцоно. Баярын хурлыг Зохион байгуулах хорооны дарга удирдана.

Төр, засгийн удирдах албан тушаалтан баярын хуралд илтгэл тавина. Хурлыг нээхэд Зэвсэгт хүчний генжиал штабын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим /цаашид "Үлээвэр найрал хөгжим" гэх/ Төрийн дуулал эгшиглүүлнэ.

7.2. Наадмаар энэ журмын 7.1-д зааснаас гадна төрийн ёслолын дараахь арга хэмжээг зохион байгуулна:

7.2.1. 7 дугаар сарын 11-нд Төв цэнгэлдэх хүрээлэнд энэ журам болон Зохион байгуулах хорооны баталсан хөтөлбөрийн дагуу Наадмын нээлтийг хийнэ;

а/ Төв цэнгэлдэх хүрээлэнгийн Төв асарт Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд суудалтай улс төрийн намуудын дарга, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, нийслэлийн Засаг дарга, Зүүн асарт Улаанбаатар хот дахь Дипломат төлөөлөгчийн газруудын тэргүүн, гадаадын зочид төлөөлөгчид, Баруун асарт ТӨ-VA, ТӨ-VI-д хамаарах албан тушаалтан, ТӨ-I, ТӨ-II-т хамаарах алба хашиж явсан төрийн зүтгэлтнүүд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга, ахмадын төлөөлөгчид тус тус сууна. ТӨ-VIA-д хамаарагдах албан тушаалтнууд урилгаар оролцоно;

б/ Төв цэнгэлдэх хүрээлэнд Төрийн далбаа мандуулсан байна. Наадмыг нээх цаг болоход Төрийн тугийг хүндэтгэн залах ёслол эхэлнэ. Төрийн тугийг залмагч Монгол Улсын Ерөнхийлөгч Төв асраас цагаан эсгий дээгүүр залран ёслолын тавцанд гарч Төрийн туганд ёслол Наадмын ажиллагааг нээж үг хэлнэ. Үг хэлж дуусахад Үлээвэр найрал хөгжим Төрийн дуулал эгшиглүүлнэ. Энэ үед наадамчид суудлаасаа босч Төрийн дууллыг даган дуулж хүндэтгэл үзүүлнэ. Зохион байгуулах хорооны дарга, Төрийн ёслолын албаны дарга нар Монгол Улсын Ерөнхийлөгчийг дагалдана;

в/ Монгол Улсын Ерөнхийлөгч Төв асарт эргэн ирж байраа эзлэнээр Наадмын нээлтийн арга хэмжээг хөтөлбөрийн дагуу явагдана. Үндэсний бөхийн барилдааны нэгийн даваа эхэлнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд үндэсний сурын харвааны талбайд очиж сур харвах, үзэж сонирхоно. Мөн хурдан морины барманы газар очиж морины уралдаан үзнэ;

7.2.2. Монгол Улсын Ерөнхийлөгч Наадмыг тохиолдуулан 7 дугаар сарын 11-нд төрийн дийллага хийнэ. Дайллагад ТӨ-II-оос ТӨ-

VIA-д хамаарах албан тушаалтан нар болон гадаад орны өндөр хэмжээний зочид төлөөлөгчид, Дипломат төлөөлөгчдийн газруудын тэргүүн, олон улсын байгууллагын төлөөлөл, Зохион байгуулах хорооны гишүүд урьд жилийн наадамд түрүүлсэн, үзүүрлэсэн бөх, түрүүлсэн зургаан насны морины эзэн, түрүүлсэн мэргэн харваач, ажил хэрэгч хүмүүс, иргэдийн төлөөлөгчдийг урилгаар оролцуулах бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч төрийн дийллагыг нээж үг хэлнэ;

7.2.3. 7 дугаар сарын 12-нд Наадмын үйл ажиллагаа үргэлжилнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд Төв цэнгэлдэх хүрээлэнд хүрэлцэн очиж үндэсний бөхийн барилдаан, бусад уралдаан тэмцээн үзнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч түрүүлсэн, үзүүрлэсэн бөх, түрүүлсэн мэргэн харваач нарт шагнал, түрүүлсэн, айрагдсан морь унасан хүүхдүүдэд бэлэг гардуулна. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн дагуу Зохион байгуулах хорооны саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч улсын цолны болзол хангасан бөх, харваачид улсын цол олгож, цолны тэмдэг, үнэмлэхийг гардуулна. Зохион байгуулах хороо түрүүлсэн, айрагдсан морины эзэд шагнал, бөхчүүдэд цолны чимэг олгож үнэмлэхийг гардуулна;

7.2.4. Монгол Улсын Ерөнхийлөгч Наадмын ажиллагааг хааж үг хэлнэ. Төрийн тугийг Төв цэнгэлдэх хүрээлэнгээс Төрийн ордонд буцаан залах ёслол болно.

7.3. Наадмыг орон нутагт болон гадаадад тэмдэглэн өнгөрүүлэх

7.3.1. Наадамд зориулан хүндэтгэлийн концерт тоглох бөгөөд концерт нээхэд Төрийн дуулал эгшиглүүлнэ. Уламжлал ёсоор эрийн гурван наадам хийнэ. Орон нутгийн удирдлага хүлээн авалт хийж болно;

7.3.2. Аймаг, хот, сум байгуулсны тэгш ойг Наадамтай хамтатган тэмдэглэнэ. Онцгойлон үзэх шалтгаантай бол Засгийн газрын шийдвэрээр ойг тэмдэглэх өдрийг шилжүүлж болно;

7.3.3. гадаадад суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газрууд, олон улсын байгууллагын дэргэдэх төлөөлөгчийн газрууд /цаашид "Дипломат төлөөлөгчийн газар" гэх/ Наадмыг суугаа орондоо боломжтой хэлбэрээр тэмдэглэнэ.

7.4. Бүгд Найрамдах Улс тунхагласны баяр

7.4.1. Монгол Улсын Их Хурлын дарга ард түмэндээ хандаж радио, телевизээр үг хэлнэ.



7.4.2. Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлж, Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөнө.

7.4.3. үндэсний бөхийн барилдаан зохион байгуулна.

7.5. Цагаан сар

7.5.1. Монгол Улсын Ерөнхийлөгч ард түмэндээ хандаж радио, телевизээр үг хэлнэ. Дараа нь морин хуурын хүндэтгэлийн тоглолтыг нэвтрүүлнэ.

7.5.2. Битүүнд үндэсний бөхийн барилдаан зохион байгуулна.

7.5.3. Шинийн нэгэнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Их эзэн Чингис хааны хөшөө, Төрийн туганд хүндэтгэл үзүүлнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд Гандантэгчэнлин хийдийн Очирдара, Жанрайсиг бурханд хүндэтгэл үзүүлж болно. Золголт хийж, Төрийн их хан хуурын сүлд аялгууг эгшиглүүлж морин цагт морин хуурын хүндэтгэлийн тоглолтыг радио телевизээр давтан нэвтрүүлнэ.

7.5.4. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн дагуу Зохион байгуулах хорооны саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч улсын цолны болзол хангасан уяачид улсын цол олгож, цолны тэмдэг, үнэмлэхийг гардуулна.

7.6. Шинэ жил

7.6.1. Монгол Улсын Ерөнхийлөгч ард түмэндээ хандаж радио, телевизээр үг хэлнэ.

7.6.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд Монголын хүүхдийн байгууллагаас эрхлэн зохион байгуулах нийслэлийн хүүхдийн сүлд модны наадамд оролцоно.

7.6.3. Төрийн ордонд Ерөнхий сайд оны шилдэг хүүхдүүдэд батламж шагналыг гардуулна.

7.7. Олон улсын эмгэтэйчүүдийн өдөр

7.7.1. асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн радио, телевизээр үг хэлж, ёслолын арга хэмжээ зохион байгуулна.

7.8. Их эзэн Чингис хааны мэндэлсэн өдөр

7.8.1. Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлнэ.

7.8.2. тэгш ой тохиосон жил тусгай хөтөлбөрөөр тэмдэглэж болно.

7.9. Хүүхдийн баяр

7.9.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд Д.Сүхбаатарын талбайд болон бусад газарт зохиогдох баярын арга хэмжээнд оролцож болно.

8. Нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр

8.1. Монгол Улсын Үндсэн хуулийн өдөр

8.1.1. Монгол Улсын Их Хурлын дарга ард түмэндээ хандаж радио, телевизээр үг хэлнэ.

8.1.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөнө.

8.1.3. үндэсний бөхийн барилдаан зохион байгуулна.

8.1.4. тэгш ойгоор нь онол-практикийн бага хурал зохион байгуулж, Монгол Улсын Ерөнхийлөгч дийллага хийж болно.

8.2. Эх орончдын өдөр

8.2.1. Засгийн газрын гишүүн тэргүүлсэн Комиссын баталсан төлөвлөгөөний дагуу тэмдэглэнэ.

8.3. Зэвсэгт хүчний өдөр

8.3.1. Батлан хамгаалах яам, зэвсэгт хүчний удирдлага, цэргийн дээд цолтонууд Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөнө. Төр, засгийн удирдах албан тушаалтан нар оролцоно. Хүндэтгэлийн концерт тоглоно.

8.3.2. тэгш ойгоор нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөнө.

8.4. Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын өдөр

8.4.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд Хэлмэгдэгсдийн дурсгалын хөшөөнд цэцэг өргөнө.

8.4.2. Сонгинохайрхан дахь Хэлмэг-дэгсдийн булшинд төр, засгийн удирдагчдын нэрийн өмнөөс цэцэг өргөнө. Улсын Их Хурал, Засгийн газрын зарим гишүүн, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон холбогдох яамдын төлөөлөгчид, Цагаатгах ажлыг зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн дарга нар оролцоно.

8.5. Ардчилал, хүний эрхийн өдөр

8.5.1. Засгийн газрын гишүүн тэргүүлсэн Комиссын баталсан төлөвлөгөөний дагуу тэмдэглэнэ.

8.6. Үндэсний эрх чөлөөний өдөр

8.6.1. Монгол Улсын Ерөнхий сайд ард түмэндээ хандаж радио, телевизээр үг хэлнэ.

8.6.2. Монгол Улсын Төрийн тамганы хөшөөнд цэцэг өргөнө.

9. Монгол Улсын Ерөнхийлөгч тангараг өргөх

9.1. Монгол Улсын Их Хурал Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль батлагдсаны дараа Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлаас товлосон өдөр, цагт Улсын Их Хуралд Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу тангараг өргөнө.

9.2. Тангараг өргөх ёслолыг "Журам батлах тухай" Улсын Их Хурлын 1993 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 40 дүгээр тогтоолын дагуу зохион байгуулна.

10. Улсын Их Хурлын гишүүн тангараг өргөх

10.1. Улсын Их Хурлын анхдугаар чуулган бүрэн эрхийг нь зөвшөөрсний дараа Улсын Их Хурлын гишүүд Төрийн сүлдэнд тангараг өргөнө. Тангараг өргөх ажиллагааг Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд заасны дагуу зохион байгуулна. Тангараг өргөмөгц Үлээвэр найрал хөгжим Төрийн дуулал эгшиглүүлнэ.

10.2. Улсын Их Хурлын нөхөн сонгуулийн дун хүчин төгөлдөр гэж үзсэн тогтоолыг Улсын Их Хурал баталж шинээр сонгогдсон гишүүний бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсний дараа тухайн гишүүн энэ журамд заасны дагуу тангараг өргөнө.

11. Улсын Их Хурлын анхдугаар чуулганы нээлт

11.1. Монгол Улсын Ерөнхийлөгч чуулганы хуралдааныг даргалж түүнийг нээж үг хэлнэ. Үг хэлсний дараа Үлээвэр найрал хөгжим Төрийн дуулал эгшиглүүлнэ.

11.2. Анхдугаар чуулганы хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын түүрүүчийн дарга, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Улаанбаатар хот дахь гадаадын Дипломат төлөөлөгчийн газруудын тэргүүн нар болон бусад хүмүүс урилгаар оролцоно.

12. Уул, овооны тэнгэрийг тайх төрийн тахилга

12.1. Төрийн тахилгатай Бурхан Халдун уул, Богд хан хайрхан уул, Отгонтэнгэр уул, Алтан хөхийн уул, Сутай хайрхан уул, Хан хөхийн уул, Суварга хайрхан уулын тэнгэрийг тайх, Дарьгангын Дара овоог тахиx төрийн тахилгын ёслолыг "Уул овооны тэнгэрийг тайх төрийн тахилгын ёслолыг үйлдэх тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 57 дугаар зарлигаар батлагдсан журмын дагуу үйлдэнэ.

13. Хөрөг байрлуулах

13.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын албан тушаал хашиж байсан хүмүүсийн хөргийг Төрийн ордонд ёслол хүндэтгэлтэйгээр байрлуулна.

14. Тамга шилжүүлэх

14.1. Монгол Улсын Ерөнхийлөгчид Төрийн тамга шилжүүлэх ёслолын ажиллагаа нь "Журам батлах тухай" Улсын Их Хурлын 1993 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 40 дүгээр тогтоолын дагуу явагдана.

14.2. Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хуралдаанаар Улсын Их Хурлын даргыг сонгомогц Улсын Их Хурлын Тамга шилжүүлэх ёслол болно. Шинээр сонгогдсон Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын Тамгыг гардаж адис аваад Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

14.3. Ерөнхий сайдыг томилмогц Засгийн газрын Тамгыг шилжүүлэх ёслол Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө /"Соёмбо" танхим/-нд болно. Ёслолд Монгол Улсын Ерөнхийлөгч оролцоно. Засгийн газрын гишүүд байлцана.

14.4. Монгол Улсын Ерөнхийлөгч шинээр томилогдсон Ерөнхий сайдыг дагуулан өргөөнд орж ирж зогсоход түрүүчийн Ерөнхий сайд Засгийн газрын Тамгыг шинээр томилогдсон Ерөнхий сайдад гардуулна. Ерөнхий сайд Тамгыг гардаж адис аваад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад хадгалуулна.

14.5. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга дахин сонгогдох, Ерөнхий сайд улиран томилогдох тохиолдолд Тамга шилжүүлэх ёслол үйлдэхгүй.

15. Улсын цол, төрийн шагнал, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах

15.1. Улсын цол, төрийн шагнал, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах ёслол "Соёмбо" танхим /Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө/-д болно. Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын цол, төрийн шагнал, цэргийн дээд цол хүртээж, одон медалиг гардуулна. Ёслолд Улсын Их Хурал, Засгийн газрын холбогдох гишүүн, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга байлцана.

15.2. Улсын цол, төрийн шагнал, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнагдах хүмүүс "Соёмбо" танхим /Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө/-ын баруун талд зогссон байна.

15.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг уншихад Монгол Улсын Ерөнхийлөгч улсын цол, шагналын тэмдэг, одон медалиг зүүж, үнэмлэхийг гардуулж өгнө. Улсын цол, шагнал хүртээгчдийн төлөөлөгч талархал илэрхийлж хариу үг хэлж болно.

15.4. Монгол Улсын Засгийн газрын "Хүндэт өргөмжлөл" шагнал гардуулах ёслолыг улсын цол, төрийн шагнал, цэргийн дээд цол хүртээх ёслолын жишгээр гүйцэтгэнэ. Ерөнхий сайд шагналыг олгож, Засгийн газрын холбогдох гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нар байлцана.

15.5. Монгол Улсын Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдын даалгавраар эрх бүхий албан тушаалтан аймаг, нийслэлд шагнал гардуулж болно.

16. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын дэд дарга, Шадар сайд орон нутагт ажиллах

16.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг орон нутагт ажиллахад Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн зичгийн дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын

дарга тус тусын чиглэлээр Төрийн ёслолын албаны даргын хамт, Улсын Их Хурлын дэд дарга болон Шадар сайдыг Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Төрийн ёслолын албаны ажилтан тус тус үдэж, угтана.

16.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд аймаг, сумын төвд хүрэлцэн очиход аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга нар угтаж, үднэ.

16.3. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд сонгогдож, томилогдсоныхоо дараа анх удаа очиход тухайн аймгийн төвд хүндэтгэн угтана.

17. Ёслолын арга хэмжээнд оролцох

17.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг ёслолын арга хэмжээнд урьсан бүх урилгыг Төрийн ёслолын алба, Төрийн дипломат ёслолын газраар дамжуулан, Урилгыг Төрийн ёслолын алба Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдад танилцуулж шийдвэрлүүлнэ.

17.2. Төрийн ёслолын алба Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурал болон Засгийн газрын гишүүдийг урьсан урилгыг хүлээн авч зохицуулан өөрсөд нь мэдэгдэж байна.

17.3. Улаанбаатар хот дахь Дипломат төлөөлөгчийн газраас зохиох арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурорыг хэрхэн оролцуулахыг Төрийн дипломат ёслолын газар шийдвэрлэнэ.

17.4. Засгийн газрын гишүүд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор ёслолын арга хэмжээ, уулзалтын үеэр гадаадын Дипломат төлөөлөгчийн газрын зүгээс аман урилга авбал хэрхэх тухайгаа Төрийн дипломат ёслолын газраар дамжуулан албан ёсоор мэдэгдэж байна.

17.5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шугамаар Төрийн ордонд болох төрийн ёслолын бүх арга хэмжээг Төрийн ёслолын алба эрхлэн зохион байгуулна.

18. Бэлэг дурсгалын зүйл хүлээн авах, өгөх

18.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд бэлэг дурсгалын зүйл хүлээн авах, өгөх асуудлыг "Зардлын норматив,



журал батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 198 дугаар тогтоолын дагуу шийдвэрлэж байна.

18.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас шаардагдах зардлыг гаргаж бэлэг дурсгалын санг бүрдүүлнэ.

19. Цэцэг өргөх

19.1. Д Сүхбаатарын хөшөөнд:

19.1.1. хөшөөний урд талд Төрийн хүндэт харуул /цаашид “Хүндэт харуул” гэх/, Үлээвэр найрал хөгжим хөшөө рүү харан жагсах бөгөөд хөшөөний зүүн талаас хөшөө хүртэл цэцэг өргөх замын турш гудаслаг нарийн хивс, цэцэг өргөх газарт хивс тус тус дэвсэж, хивсний үзүүр талд цэцгийг өргөх дарааллаар байрлуулна;

19.1.2. цэцэг өргөх цаг болоход Үлээвэр найрал хөгжим “Шивээ хианг” аяыг эгшиглүүлж цэцэг өргөх ёслолын ажиллагаа эхэлнэ. Хүндэт харуулын цэргүүд цэцгийг хос хосоороо барьж хүндэтгэлийн алхаагаар явж дэвссэн хивсэн дээр дарааллын дагуу баруун, зүүн тал руу нь ээлжлүүлэн байрлуулна. Цэцэг өргөгсөд цэцгийн өмнө мэхийн ёслоод хөшөөг нар зөв тойрч, хөшөөний зүүн талд гаран цэцэг өргөсөн дарааллаар Төрийн ёслолын цэргийн цагаан туг /цаашид “Цагаан туг” гэх/ руу харж цуван зогсоно;

19.1.3. цэцэг өргөх ёслолын ажиллагаа дуусахад Үлээвэр найрал хөгжим Төрийн дуулал, цэцэг өргөгсөд тарж явахад “Баярын марш” эгшиглүүлнэ.

19.2. Хэлмэгдэгсдийн дурсгалын хөшөөнд:

19.2.1. Хөшөөний баруун талбайд Хүндэт харуул, Үлээвэр найрал хөгжим жагсана. Хөшөө хүртэл гудаслаг нарийн хивс дэвсэж хивсний үзүүрээс эхлэн цэцгийг өргөх дарааллаар байрлуулна;

19.2.2. цэцэг өргөх ёслолын ажиллагаа эхлэхэд Үлээвэр найрал хөгжим “Эмгэнэн дуурсах” аялгуу эгшиглүүлнэ. Хүндэт харуулын цэргүүд цэцгийг хос хосоороо барьж хүндэтгэлийн алхаагаар явж хөшөөний өмнө талд дараалуулан байрлуулна. Цэцэг өргөгсөд цэцгийн өмнө мэхийн ёслоод шатаар өгсөн хөшөөг нар зөв бүтэн тойрч хөшөөний зүүн талд гаран цэцэг өргөсөн дарааллаар Цагаан туг руу харж зогсоно;

19.2.3. цэцэг өргөх ёслолын ажиллагаа дуусахад Үлээвэр найрал хөгжим Төрийн дуулал, цэцэг өргөгсөд тарж явахад “Алдар марш” эгшиглүүлнэ

19.3. Хэлмэгдэгсдийн булшинд:

19.3.1. булшны гадна зүүн талбайд Хүндэт харуул, Үлээвэр найрал хөгжим жагсана. Булшны хайсны хаалга хүртэл гудаслаг нарийн хивс дэвсэж цэцгийг өргөх дарааллаар байрлуулна;

19.3.2. цэцэг өргөх ёслолын ажиллагаа эхлэхэд Үлээвэр найрал хөгжим “Эмгэнэн дуурсах” аялгуу эгшиглүүлнэ. Хүндэт харуулын цэргүүд цэцгийг хос хосоороо барьж хүндэтгэлийн алхаагаар явж булшны хайсан дотор орж булшны өмнөх тавцанд дараалуулан байрлуулна. Цэцэг өргөгсөд цэцгийн өмнө мэхийн ёслоод булшны хайсны гадна талаар нар зөв тойрон явж булшны баруун хэсэгт цэцэг өргөсөн дарааллаар цуван зогсоно;

19.3.3. цэцэг өргөх ёслолын ажиллагаа дуусахад Үлээвэр найрал хөгжим Төрийн дуулал, цэцэг өргөгсөд тарж явахад “Алдар марш” эгшиглүүлнэ.

20. Эмгэнэн гашуудах ёслол

20.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд таалал төгсөхөд:

20.1.1. Улсын Их Хурал, Засгийн газраас таалал төгссөн тухай гүн эмгэнэлтэйгээр мэдэгдэж талийгаачийн зураг, намтрыг сонин хэвлэлд нийтлүүлэн, радио телевизээр нэвтрүүлж, Улаанбаатар хот дахь Дипломат төлөөлөгчийн газруудад ноотоор мэдээлнэ;

20.1.2. Засгийн газраас талийгаачийг оршуулах ажлыг зохион байгуулах комисс томилох бөгөөд уг Комисс орон даяар гашуудал зарлах өдрүүдийг тогтооно. Талийгаачийн шарилыг хаана байрлуулж, ямар хугацаанд салах ёс гүйцэтгэх, хэзээ, хаана оршуулахыг шийдвэрлэж зарлана;

20.1.3. Төрийн далбааг гашуудлын өдрүүдэд 45 хэмээр бөхийлгөх буюу ишний нь гуравны хоёрт хүртэл буулгана. Орон даяар урлагийн тоглолт, кино зэрэг баяр цэнгэлийн үйл ажиллагаа явуулах, ёслолын арга хэмжээ зохиохыг хориглоно;

20.1.4. найрсаг харилцаат орнуудаас төлөөлөгч ирж оршуулах ёслолд оролцох асуудал тавибал комисс шийдвэрлэж хариу өгнө.

20.2. Салах ёс гүйцэтгэх

20.2.1. салах ёс гүйцэтгэх танхимын гадаа гол хаалган дээр талийгаачийн хөргийг байрлуулна. Танхимын цонх, чийдэнг эмгэнэлийн байдлаар бүдгэрүүлэн бүтээж, ногоон шилмүүсээр чимэглэнэ;

20.2.2. танхимын хоймор талд тусгай зассан тавцан дээр шарилыг байрлуулж, сагстай амьд цэцэг тойруулан тавина. Танхимд байнга арц, хуж асаана. Хүндэт харуулын цэргүүд шарилыг хүндэтгэн хамгаалж зогсоно;

20.2.3. шарилын хайрцагны тагийг тэнгэрийн өнгөт хөх цэнхэр, хайрцгийг дэлхийн өнгөт ногоон торгоор доторлож, гадна талыг цагаан өнгийн материалаар бүрсэн байна. Шарилын хайрцгийг алтан саатай шар бүсээр гурав бүсэлсэн байдлаар бэхлэхээр бэлтгэнэ;

20.2.4. талийгаачийн жаазтай том зургийг шарилын толгой талд тусгай бүрээстэй өндөр тавцан дээр байрлуулж хадгаар бүтээн, жаазны зүүн доод өнцгийг хар, улаан даавуугаар чагтална. Зургийн баруун талд Төрийн далбааг бөхийлгөн зална;

20.2.5. салах ёс гүйцэтгэх ажиллагаа эхэлмэгц талийгаачийн гэр бүл, төрөл төрөгсөд, Комиссын гишүүд болон төр, засгийн тэргүүн нар шарилын дэргэд хүндэтгэл үзүүлнэ;

20.2.6. салах ёс гүйцэтгэхээр хүрэлцэн ирсэн хүмүүс Комиссын зохион байгуулснаар салах ёс гүйцэтгэнэ;

20.2.7. салах ёс гүйцэтгэх ёслол эхлэхээс дуусах хүртэл Симфони найрал хөгжим гашуудлын аялгуу эгшиглүүлж байна.

20.3. Оршуулах

20.3.1. шарилыг танхимаас гаргахын өмнө Комиссын гишүүд, талийгаачийн гэр бүл, төрөл төрөгсөд хүндэтгэл үзүүлж зогсоно;

20.3.2. шарил байрласан танхимын босгон дээр нь хөндлөн мод тавьж, шарилаа толгой талаар нь гаргаж шарил ачих машинд дэвссэн цагаан эсгийн дээр толгойг нь явах зүг рүү харуулж зална;

20.3.3. гашуудлын цуваа оршуулах газрын зүг алгуурхан хөдөлнө. Цувааг талийгаачийн зураг, албан байгууллага, хүмүүсээс тавьсан цэцэг, шарил ачсан машин түүний дараа Комиссын гишүүд, төр, засгийн тэргүүн нар, талийгаачийн гэр бүл, төрөл, төрөгсөд, ёслолд оролцогчид гэсэн дарааллаар хөдөлгөнө. Цувааг Үлээвэр найрал хөгжим дагалдан явж гашуудлын аялгуу эгшиглүүлнэ;

20.3.4. цуваа "Алтан-Өлгий" хүндэтгэлийн оршуулгын газрын "А" хэсэгт ирж, шарилыг машинаас буулган цагаан эсгийг дээр зассан суурь дээр байрлуулна. Талийгаачийн зураг болон тавьсан цэцгийг шарилын баруун, зүүн талд нь

барьж зогсоно. Төр, засгийн тэргүүн нар, Комиссын гишүүд болон оршуулах ёслолд оролцогчид байраа эзэлнэ;

20.3.5. Комиссын дарга гашуудлын цуглааныг нээж үг хэлнэ. Цуглаан дээр гэр бүл, төрөл төрөгсөд болон иргэдийг төлөөлж тус бүр нэг хүн үг хэлж болно. Комиссын дарга цуглааныг хааж үг хэлэхэд Үлээвэр найрал хөгжимд гашуудлын аялгуу эгшиглэнэ;

20.3.6. гэр бүл, төрөл төрөгсөд нь салах ёс гүйцэтгэхэд гашуудлын аялгууг зогсооно. Хайрцагны тагийг хааж бэхлэхэд Үлээвэр найрал хөгжимд гашуудлын аялгуу эгшиглэнэ. Шарилыг нүхэнд байрлуулж, эх газрын алтан хөрсөнд далдална. Энэ үед гашуудлын аялгууг зогсоож их буугаар ёслолын буудлага хийнэ. /Монгол Улсын Ерөнхийлөгч таалал төгсөхөд 21 удаа, Улсын Их Хурлын дарга бууу Ерөнхий сайд таалал төгсөхөд 19 удаа/ Үлээвэр найрал хөгжимд Төрийн дуулал эгшиглэнэ. Бөхийлгөсөн Төрийн далбааг хэвийн байдлаар мандуулна;

20.3.7. Комиссоос гашуудал тайлах цагаалга хийнэ. Цагаалга дээр Комиссын дарга үг хэлж гашуудал тайлна;

20.3.8. оршуулах ёслолд гадаадын төлөөлөгчид ирвэл тэднийг ямар нэгэн ёслолгүйгээр угтаж, үднэ.

20.4. Тус улсаас гадаадад суугаа Дипломат төлөөлөгчийн газрууд

20.4.1. таалал төгссөн тухай мэдээ авмагц суугаа орны Гадаад хэргийн яам болон тэнд суугаа Дипломат төлөөлөгчийн газруудад ноотоор мэдээлнэ. Ноот нь ёслол хүндэтгэлийн үгүй байх бөгөөд Дипломат төлөөлөгчийн газарт эмгэнэл илэрхийлэх цагийг заана;

20.4.2. талийгаачийн хөргийг жаазлан, жаазны зүүн доод өнцгийг хар, улаан даавуугаар чагтлан гашуудлын байдлаар бэлтгэн тусгай танхимд зассан өндөр тавиур дээр байрлуулж, эргэн тойрон амьд цэцгээр чимэглэнэ. Зургийн баруун талд Төрийн далбааг бөхийлгөн зална. Танхимд эмгэнэлийн дэвтэр бэлтгэж, ширээн дээр тавина;

20.4.3. суугаа орны удирдагчид болон иргэдийн төлөөлөгчид, Дипломат төлөөлөгчийн газруудаас эмгэнэл илэрхийлэхээр ирэхэд нь Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн дипломатуудын хамт хүлээн авч, явахад нь талархал илэрхийлж байна;

20.4.4. Дипломат төлөөлөгчийн газрын албан байр дээр Төрийн далбааг гашуудлын

өдрүүдэд 45 хэмээр бөхийлгөх буюу ишний нь гуравны хоёрт хүртэл буулган эмгэнэл илэрхийлнэ.

20.5. Төр, засгийн удирдах албан тушаалтан таалал төгсөхөд

20.5.1. эмгэнэлийн бичигт Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Улсын Их Хурал, Засгийн газрын холбогдох гишүүд гарын үсэг зурж хэвлэлд нийтэлж, радио телевизээр мэдээлнэ;

20.5.2. салах ёс гүйцэтгэх, оршуулахдаа энэхүү журмын 20.2.4-20.2.7, 20.3.1-20.3.3, 20.3.5-д заасныг жишиг болгох бөгөөд орон даяар гашуудал зарлахгүй. Төрийн далбааг бөхийлгөх буюу буулгахгүй, шарил байрлуулсан байрны гадна талд талийгаачийн хөрөг зургийг байрлуулахгүй, оршуулгын газарт Үлээвэр найрал хөгжим Төрийн дуулал эгшиглүүлнэ. Оршуулгын ажиллагаа "Алтан-Өлгий" хүндэтгэлийн оршуулгын газрын "Б" хэсэгт болно;

20.5.3. ТӨ-I, ТӨ-II-т хамаарах албан тушаал хашиж явсан төрийн зүтгэлтэн, ТӨ-III-т хамаарагдах албан тушаалтан таалал төгсөхөд энэхүү журмын 20.5.2-т заасныг мөрдөн тэдний оршуулгын ажиллагаа "Алтан-Өлгий" хүндэтгэлийн оршуулгын газрын "А" хэсэгт болно. Төр, засгийн удирдах албан тушаал хашиж байсан хүмүүсийг оршуулгын газрын "Б" болон "В" хэсэгт нутаглуулна.

20.6. Эмгэнэлийн бичиг үйлдэх:

20.6.1. Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, төрийн шагналтан, ардын цолтны эмгэнэлийн бичигт Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Улсын Их Хурал, Засгийн газрын холбогдох гишүүд гарын үсэг зурна;

20.6.2. гавъяат цолтон, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, Элчин, цэргийн дээд цолтны эмгэнэлийн бичигт Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд болон Улсын Их Хурал, Засгийн газрын холбогдох гишүүд гарын үсэг зурна;

20.6.3. Төрийн ёслолын алба Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд гарын үсэг зурсан эмгэнэлийн бичгийг хэвлэлд нийтлэх, радио телевизээр мэдээлэх зөвшөөрөл олгоно.

МОНГОЛ УЛСЫН ДИПЛОМАТ ЁСЛОЛ

21. Дипломат ёслолын ахлал

21.1. Дипломат ёслолын ахлаалыг тогтоохдоо Үндэсний ёслолын ахлаалыг баримтлах бөгөөд гадаад улсад суугаа Элчин сайд, Байнгын

төлөөлөгч нь ТӨ-Ү-д дурдсан зэрэг зиндаатай, Гадаад хэргийн дэд сайд, Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын гадаад бодлогын зөвлөх нь энд дурдсан дарааллаар ахлал баримтлан ёслолын үйл ажиллагаанд оролцоно.

21.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайдын айлчлалын үеэр Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайд, олон улсын байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч нь ёслолын ахлалаар Гадаад хэргийн сайдын дараа орно.

22. Итгэмжлэх болон эгүүлэн татах жуух бичиг, захидал үйлдэх

22.1. Итгэмжлэх жуух бичиг, Эгүүлэн татах жуух бичиг /цаашид "Жуух бичиг" гэх/ Итгэмжлэх захидал, Эгүүлэн татах захидал /цаашид "Захидал" гэх/-ыг 33 x 22 см хэмжээний хамар буюу нугалбар цагаан цаасан дээр үйлдэнэ. Нүүрэн талд нь Төрийн сүлдийг товойлгосон байх бөгөөд түүний доод хэсэгт "Монгол Улсын Ерөнхийлөгч...", "Монгол Улсын Ерөнхий сайд..." гээд эцэг, эхийн болон өөрийн нь нэрийг худам монгол бичгээр голлуулан бичиж хэвлэсэн байна. Жуух бичиг болон Захидалд орчуулгыг холбогдох гадаад хэлээр үйлдэн хавсаргана.

22.2. Жуух бичигт Монгол Улсын Ерөнхийлөгч, Захидалд Монгол Улсын Ерөнхий сайд тус тус гарын үсэг зурна. Гадаад хэргийн сайд Жуух бичиг болон Захидлыг баталгаажуулан гарын үсэг зурна.

22.3. Жуух бичиг болон Захидлын дугтуйн гадна талд худаам монгол бичгээр "...Улсын Ерөнхийлөгч /Эзэн хаан(Хатан хаан) Эрхэмсэг ноён (хатагтай)..... Танаа", "..... Байгууллагын Танаа"/ гэх зэрэг албан тушаалынх нь дараа тухайн хүний нэрийг бүтнээр нь бичнэ.

22.4. Дугтуйг битүүмжлэхгүй бөгөөд дугтуйн амсрын гурвалжин дээр Төрийн сүлдийг товойлгож хэвлэсэн тусгай даруулга наасан байна.

23. Гадаадын Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнийг угтах, үдэх

23.1. Гадаадын Дипломат төлөөлөгчийн газрын шинээр томилогдсон тэргүүн /цаашид "Элчин сайд" гэх/ анх удаа хүрэлцэн ирэх, бүр мөсөн буцахад нисэх онгоц буюу галт тэрэг /цаашид "буудалд" гэх/-ний буудалд Төрийн дипломат ёслолын газрын ахлах тушаалын ажилтан угтаж, үднэ.

23.2. Элчин сайдыг Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, түүний эзгүйд

Дипломат ёслолын газрын дарга хүлээн авч түүний Жуух бичиг болон өмнөх Элчин сайдыг эгүүлэн татах Жуух бичгийн хувийг хүлээн авна.

23.3. Элчин сайдыг үүрэгт ажилдаа эхлэн орох гэж байгаатай нь холбогдуулан Дипломат ёслолын газрын дарга хүлээн авч, Жуух бичиг буюу Захидал гардуулах ёслолын журмыг тайлбарлаж өгнө.

23.4. Монгол Улсын Ерөнхийлөгчид Жуух бичиг барих товыг тус улсад байнга суух Элчин сайд хүрэлцэн ирснээс хойш 15 хоног, хавсран суух Элчин сайдыг хүсэлт гаргаснаас нь хойш 1 сарын дотор Дипломат ёслолын газар Элчин сайдад мэдэгдэн, хэрэгжүүлнэ.

24. Жуух бичиг барих

24.1. Төрийн ордны гол хаалганы зүүн гар талын багананд Монгол Улсын, баруун гар талын багананд тухайн улсын 3 x 1.5 м, эсхүл ойролцоо хэмжээтэй Төрийн далбааг тус тус мандуулна.

24.2. Төрийн ордны өмнөх талбайд Хүндэт харуул, Үлээвэр найрал хөгжим ордны зүг харж жагсана. Цагаан туг жагсаалын эхэнд байрлана.

24.3. Төрийн дипломат ёслолын газрын дарга Жуух бичиг гардуулах ёслол эхлэхээс 10 минутын өмнө Элчин сайдыг ёслолын автомашинаар Төрийн ордонд залж авчирна. Жуух бичиг гардуулах ёслолд Элчин сайдын гэргий /нөхөр/, 3-аас илүүгүй дипломат ажилтан дагалдан оролцож болно.

24.4. Ёслолын автомашин Төрийн ордон руу ирэх үед Үлээвэр найрал хөгжимд "Угтах марш" эгшиглүүлэх бөгөөд ёслол болох талбайд ирэхэд Төрийн ордны хамгаалалтын офицер машины хаалгыг онгойлгож Элчин сайдыг хүндэтгэн ёсолно. Энэ үед бусад машинуудыг Элчин сайдын машины ард нэгэн эгнээнд цувуулан зогсооно.

24.5. Төрийн дипломат ёслолын газрын дарга Элчин сайдыг баруун гар талдаа дагуулан Хүндэт харуулын зүг алхаж тусгайлан дэвссэн хивсэн дээр очиж зогсоно. Энэ үед Элчин сайдын гэргий /нөхөр/, бусад дипломатууд Элчин сайдын машины өмнө нэг эгнээгээр баруун гар талаас дипломат ёслолын ахлалыг баримтлан зогсоно.

24.6. Хүндэт харуулын дарга "Номхон" команд бөгөөд Элчин сайдыг угтан ирж, 5 метр орчим зайд түүний өөдөөс эцлэн харж зогсоод "... Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Эрхэмсэг ноён /хатагтай/ ... Тангь хүндэтгэн Хүндэт харуул жагссан. Харуулын дарга" гээд цэргийн цол, нэрээ хэлж айлтгал өргөнө. Айлтгал өргөсний дараа Харуулын дарга баруун гар тийш

эргэн Элчин сайд өөд хараа шилжүүлэн зогсоход Үлээвэр найрал хөгжим хоёр улсын Төрийн дуулал эгшиглүүлнэ.

24.7. Төрийн дууллыг эгшиглаж дуусмагц Төрийн дипломат ёслолын газрын дарга Элчин сайдын хамт Үлээвэр хөгжмийн өмнүүр алхан өнгөрч Цагаан тугийн өмнө очоод толгой мэхийн ёсолно. Эндээс Төрийн дипломат ёслолын газрын дарга Элчин сайдыг зүүн гар талдаа дагуулан, Хүндэт харуулын урдуур явж дунд хэсэгт нь хүрч зогсоход Элчин сайд зүүн гар тийш эргэн зогсож "Дайчид аа сайн байцгаана уу?" гэж мэндэлнэ. Хүндэт харуул "Амрыг эрье" хэмээн хариу мэндэлнэ.

24.8. Төрийн дипломат ёслолын газрын дарга Элчин сайдын хамт Хүндэт харуулын төгсгөлд хүрч Элчин сайдыг баруун гар талдаа дагуулан Төрийн ордны гол хаалга руу явна. Элчин сайдыг дагалдан яваа түүний гэргий /нөхөр/, дипломатууд гол хаалганд тосон ирж Элчин сайд, Дипломат ёслолын газрын даргын араас Төрийн ордонд орно. Энэ үед Төрийн ордны хамгаалалтын хоёр офицер ордны гол хаалганы гадна ёсолж хүндэтгэн өнгөрүүлнэ.

25. Жуух бичиг хүлээн авах

25.1. Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө /"Соёмбо" танхим/-ний үүдний өрөөнд Элчин сайдыг Гадаад хэргийн яамны тухайн орон хариуцсан газрын захирал /цаашид "Захирал" гэх/ угтана. Захиралтай хамт орон хариуцсан дипломат ажилтан байлцаж болно.

25.2. Төрийн дипломат ёслолын газрын дарга Элчин сайдыг Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө /"Соёмбо" танхим/-нд урьж оруулна. Өргөөний нөгөө талаас Монгол Улсын Ерөнхийлөгч, Гадаад хэргийн сайд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга нар орж ирнэ. Элчин сайдын арьс эгнээнд зүүн гар талаас Төрийн дипломат ёслолын газрын дарга, баруун гар талаас Захирал, тэдний ар талд нь Элчин сайдын гэргий /нөхөр/, дипломат ажилтан нэг эгнээгээр баруун гар талаас дипломат ёслолын ахлалыг баримтлан зогсоно.

25.3. Ёслолд оролцогсад байраа эзэлсэн даруйд Төрийн дипломат ёслолын газрын дарга "Эрхэмсэг Ноён Ерөнхийлөгчөө ... Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Эрхэмсэг ноён /хатагтай/ ... Итгэмжлэх Жуух Бичгээ гардуулахаар хүрэлцэн ирснийг айлтгая" гэж монгол хэлээр танилцуулна. Элчин сайд Монгол Улсын Ерөнхийлөгчид толгой мэхийн ёслоод өөрийн төрөлх, эсхүл аль нэг түгээмэл гадаад хэлээр "Эрхэмсэг ноён Ерөнхийлөгчөө, ... Улсын Ерөнхийлөгч /Эзэн хаан, Хатан хаан/ Эрхэмсэг ноён /хатагтай/ ... намайг Монгол Улсад суух Онц бөгөөд

Бүрэн эрхт Элчин сайдаар тохоон томилсон Итгэмжлэх жуух бичгээ гардуулах гэж байгаадаа баяртай байна” гэж хэлээд Ерөнхийлөгчийн зүг алхаж Жуух бичгээ хоёр гараар өргөн бариад буцаж байрандаа ирж зогсоно. Энэ үед Элчин сайд Ерөнхийлөгчтэй гар барихгүй, мэндлэхгүй бөгөөд буцаж алхахдаа Ерөнхийлөгчийн зүг нуруугаа харуулахгүй.

25.4. Монгол Улсын Ерөнхийлөгч Элчин сайдад хандан “Эрхэмсэг ноён Элчин сайдаа, ...Улсын Ерөнхийлөгч /Эзэн хаан, Хатан хаан/ Эрхэмсэг ноён /хатагтай/ ... Таныг ... Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар тохоон томилсон Итгэмжлэх жуух бичгийг хүлээн авч байгаадаа баяртай байна” гэж монгол хэлээр хариулах бөгөөд Ерөнхийлөгчийн үгийг орчуулахгүй.

25.5. Элчин сайд Монгол Улсын Ерөнхийлөгч рүү очиж гар барин мэндчилэх бөгөөд дагалдан яваа гэргий /нөхөр/, дипломатуудаа танилцуулна. Ерөнхийлөгч Элчин сайдад Гадаад хэргийн сайд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга нарыг танилцуулна.

25.6. Монгол Улсын Ерөнхийлөгч Элчин сайдыг урьж Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө /“Соёмбо” танхим/-ний хойморт байраа эзэлнэ. Элчин сайдтай уулзаж ярилцана. Гадаад хэргийн сайд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга уулзалтад байлцана. Албан ёсны хэлмэрч, тэмдэглэл хөтлөх ажилтан байна.

26. Хэргийг хамаарагч, суурин төлөөлөгчийг угтах, үдэх

26.1. Монгол Улсад суух гадаад улсын хэргийг хамаарагч, олон улсын байгууллагын суурин төлөөлөгч энх удаа хүрэлцэн ирэх, бүр мөсөн буцахад Төрийн дипломат ёслолын газрын ахлах тушаалын ажилтан буудалд угтаж, үднэ.

27. Захидал гардуулах

27.1. Хэргийг хамаарагч, Суурин төлөөлөгч Захидалаа Гадаад хэргийн сайдад гардуулна. Төрийн дипломат ёслолын газрын дарга Захидал гардуулах товыг Хэргийг хамаарагч, Суурин төлөөлөгчид хувийн ноотоор мэдэгдэнэ.

27.2. Хэргийг хамаарагч, Суурин төлөөлөгч Захидал гардуулах ёслолын үеэр Гадаад хэргийн яамны гол хаалганы баруун талд Монгол Улсын, зүүн талд тухайн улсын Төрийн далбаа, эсхүл олон улсын байгууллагын далбааг тус тус мандуулж, гудаслаг улаан хивс дэвсэнэ.

28. Дипломат корпус, түүнтэй харилцах

28.1. Дипломат корпус болон түүний ахлагчтай харилцах, ёслолын аливаа арга хэмжээнд оролцуулахдаа Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нарын ёслолын ахлал /Жуух бичиг барьсан хугацаа/-ыг ямагт баримтална.

28.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдтай Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нараас хийх аливаа уулзалтыг Төрийн дипломат ёслолын газар хариуцан зохион байгуулна. Эдгээр уулзалтад Гадаад хэргийн яамны холбогдох газрын захирал, хэлмэрч, тэмдэглэл хөтлөх ажилтан байлцана.

28.3. Монгол Улсын Ерөнхийлөгч гадаадын Дипломат төлөөлөгчийн газруудын тэргүүн нарт зориулан жилд нэг удаа тусгайлан арга хэмжээ зохион байгуулна.

28.4. Дипломат төлөөлөгчийн газраас зохиох үндэсний баяр, дипломат харилцаа тогтоосны тэгш бус ойн зоог, бусад арга хэмжээнд Улсын Их Хурлын дэд дарга, Монгол Улсын Шадар сайдын аль нэг нь, үндэсний баяр, дипломат харилцаа тогтоосны тэгш ойн арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын аль нэг нь тус тус тэргүүлэн Гадаад хэргийн сайд, Засгийн газрын 4-өөс илүүгүй гишүүний хамт оролцох бөгөөд Төрийн дипломат ёслолын газар тухайн ажлыг хариуцан зохион байгуулна.

28.5. Дипломат төлөөлөгчийн газар болон олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газрууд үндэсний болон байгууллагын баяр, бусад тохиолдлоор зохион байгуулах арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүдийг урих бол урилга, уригдах хүмүүсийн жагсаалтыг уг арга хэмжээ болохоос 7-оос доошгүй ажлын өдрийн өмнө Төрийн дипломат ёслолын газарт ирүүлнэ.

28.6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслол, Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хуралдаанд Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нарыг урьж оролцуулна.

29. Баяр хүргэх, баримт бичиг илгээх

29.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайд Шинэ жилийг тохиолдуулан гадаад улсын холбогдох албан тушаалтанд баяр хүргэх ажлыг тухайн оны 11 дүгээр сард багтаан гүйцэтгэнэ.

29.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайд



гадаад улс, байгууллагуудын болон хоёр талын хооронд харилцаа тогтоосны тэгш ой, бусад томоохон үйл явдлыг тохиолдуулан холбогдох албан тушаалтнуудад баяр хүргэж, цахилгаан утас илгээнэ.

29.3. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдаас илгээх дипломат баримт бичиг нь төлөөний болон нэрийн хэлбэртэй байх бөгөөд албан бичгийн хэвлэмэл хуудсан дээр үйлдэнэ. Эдгээр баримт бичгийн хэлбэр, бичвэрийг Гадаад хэргийн сайдтай зөвшилцсөний үндсэн дээр эцэслэн боловсруулж илгээнэ.

30. Эмгэнэл илэрхийлэх

30.1. Гадаад улсын төр, засгийн өндөр албан тушаалтан, Олон улсын байгууллагын болон Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн таалал төгсөхөд Монгол Улсаас түүнтэй адил буюу адилтгаж болох албан тушаалтан тэргүүлэн тухайн Дипломат төлөөлөгчийн газарт очиж эмгэнэл илэрхийлнэ.

30.2. Гадаад улсын төр, засгийн дээд болон өндөр албан тушаал хашиж байсан хүн таалал төгсөхөд Монгол Улсаас эмгэнэл илэрхийлэх хэлбэр, оролцох хүмүүсийг Төрийн дипломат ёслолын газар тодорхойлж, зохион байгуулна.

31. Гадаадын дипломат төлөөлөгчийн газрын гишүүдийг бүртгэх, үнэмлэх олгох

31.1. Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, гишүүд, тэдгээрийн гэр бүл, бусад ажилтныг Төрийн дипломат ёслолын газар бүртгэж, паспорт болон Дипломат төлөөлөгчийн газрын албан ёсны бичиг баримтад дурдсан албан тушаалыг үндэслэн ажлын 7 хоногт багтаан дараахь төрлийн хувийн үнэмлэх олгоно:

31.1.1. дипломат үнэмлэх –Д

31.1.2. ажилтны үнэмлэх –А

31.1.3. олон улсын байгууллагад ажиллагсдын үнэмлэх –ОУ

31.1.4. олон улсын байгууллагын шугамаар яам, бусад албан байгууллагад ажиллагсдын үнэмлэх –ОУТ

31.1.5. Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагууд, тэдгээрийн тэргүүн, ажилтнуудын гэрт ажиллах үйлчилгээ, техникийн ажилтнуудын үнэмлэх –ОУҮ

31.2. Энэ журмын 31.1-д заасан үнэмлэх дээр Төрийн дипломат ёслолын газрын дарга гарын үсэг зурж, тамга дарна. Шаардлагатай гэж үзвэл Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, гишүүний хүүхдийн паспорт дээр Төрийн дипломат ёслолын

газар тамга дарж, эцэг буюу эхийн хувийн үнэмлэхийн төрөл, дугаар, олгосон он, сар, өдрийг тэмдэглэж болно.

31.3. Энэхүү журмын 31.1-д дурдсан үнэмлэх эзэмшигчид албан томилолтынхоо хугацааг дуусган эх орондоо буцахдаа Төрийн дипломат ёслолын газарт албан ёсоор мэдэгдэж, үнэмлэхээ эгүүлэн хураалгаж, бүртгэлээс хасуулна.

32. Тусгай нислэгийн зөвшөөрөл олгох

32.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрөх болон Олон улсын нисэх онгоцны буудалд буулт хөөрөлтийн нислэг үйлдэх гадаад улс орны тусгай нислэгийн зөвшөөрлийг олгох ажлыг Төрийн дипломат ёслолын газар ажлын 7 хоногийн дотор зохион байгуулна.

32.2. Зөвшөөрөл хүсэгч тал тухайн онгоцонд хэн, хаанаас, хаашаа нисч байгаа, нислэгийн цагийн хуваарь, уг нисэх онгоц агаарт мөргөлдөхөөс сэргийлэх ACAS/TCAS тоноглол байгаа эсэх зэрэг мэдээллийг ноотонд дурдсан байх шаардлагатай.

33. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын айлчлал

33.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын гадаадад хийх айлчлалыг төрийн айлчлал, албан ёсны айлчлал, ажлын болон хувийн айлчлал гэж ангилж бөгөөд аливаа айлчлалыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийн дагуу хэрэгжүүлнэ. Ингэхдээ бүрэлдэхүүнийг энэхүү журмын 34-36 дугаар зүйлд заасан тоонд багтаан, айлчлал эхлэхээс 15-аас багагүй хоногийн өмнө батална. Айлчлалын албан ёсны нэр, хөтөлбөрийг Гадаад хэргийн яам хүлээн авах талтай тохиролцоно.

33.2. Төрийн айлчлалыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд хийнэ.

33.3. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын айлчлалыг хувийн хэвлийн байгууллага, хувь хүмүүсийн зардлаар хийхийг хориглоно.

33.4. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын гадаад улсад хийх айлчлалыг Гадаад хэргийн яам удирдан зохицуулж, хэрэгжүүлнэ. Улсын Их Хурлын даргын айлчлалын ёслол, үйлчилгээний холбогдолтой асуудлыг Улсын Их Хурлын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтэс зохицуулна.

33.5. Гадаад улсад айлчлах Монгол Улсын Ерөнхийлөгчийг Монгол Улсын Ерөнхий сайд

/зөвхөн Төрийн болон албан ёсны айлчлал хийхээр явахад/, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгч хувийн айлчлал хийхэд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улсын Их Хурлын даргыг айлчлахад Улсын Их Хурлын дэд дарга, Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Ерөнхий сайдыг айлчлахад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, түүнчлэн Гадаад хэргийн яамны удирдах албан тушаалтан, Төрийн дипломат ёслолын газрын ажилтан тус тус үдэж, угтана.

33.6. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын гадаад улсад хувийн айлчлал хийхэд албаны хүмүүс дагалдахгүй бөгөөд хамгаалалт, үйлчилгээний 5-аас илүүгүй хүн дагалдана. Тэднийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Гадаад хэргийн яамны холбогдох албан тушаалтан, Төрийн дипломат ёслолын газрын дарга үдэж, угтана.

33.7. Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Үндсэн хуулийн цэцийн даргын гадаадад айлчлахад Улсын дээд шүүхийн шүүгч, Үндсэн хуулийн цэцийн дэд дарга болон Төрийн дипломат ёслолын газрын ажилтан үдэж угтах бөгөөд гадаад орноос тэдгээртэй адил албан тушаалтан Монгол Улсад айлчлахад Төрийн дипломат ёслолын газар зохион байгуулж зохицуулна.

33.8. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд төрийн болон албан ёсны, Улсын Их Хурлын дарга албан ёсны айлчлал хийхээр явах, буцаж ирэхэд Буудалд Төрийн далбааг мандуулна.

33.9. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайд гадаадад айлчлах, гадаадаас ирэхэд холбогдох улс, олон улсын байгууллагаас тус улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнийг үдэх, угтах арга хэмжээнд урина.

33.10. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдад үйлчлэх монголын талын нисэх онгоц буюу галт тэрэгний дарга нисэх онгоц /галт тэрэг/ бэлэн болсныг илтэнэ.

33.11. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын айлчлалын бүрэлдэхүүнд эролцох хүмүүсийн зардлыг Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон тухайн яам, байгууллага, газрууд нь тус тус хариуцна.

33.12. Гадаад оронд хийх Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий

сайдын айлчлалын зардлыг холбогдох байгууллага, яамдын жил бүрийн төсөвт бүрэн тусгахыг Сангийн яам хариуцна.

33.13. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын гадаад оронд хийх айлчлал, түүнчлэн ёслолын бусад үйл ажиллагаатай холбогдох төсвийн төслийг Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар хариуцан боловсруулж, айлчлал эхлэхээс 10-аас доошгүй хоногийн өмнө батлуулна.

34. Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлал

34.1. Монгол Улсын Ерөнхийлөгч гадаадад төрийн болон албан ёсны айлчлалаар явахад түүний гэргий /нөхөр/, албан ёсны төлөөлөгчид, ажлын хэсэг, хамгаалалт-үйлчилгээний албаны ажилтнууд дагалдаж явна.

34.2. Монгол Улсын Ерөнхийлөгч /гэргий, нөхөр/ гадаадад төрийн буюу албан ёсны айлчлалаар явахад дагалдах хүмүүсийн тоо, нэрийг тухайн айлчлалын онцлог, ажлын шаардлагыг үндэслэн тогтоох бөгөөд энэ тоо нь 16-аас хэтрэхгүй байна.

- а. Гадаад хэргийн сайд
- б. Тухайн оронд суугаа Элчин сайд
- гэргий /нөхөр/
- в. Засгийн газрын гишүүн 1
- г. Ерөнхийлөгчийн Тамгын газраас
- 2 хүртэл хүн
- д. Гадаад хэргийн яамны холбогдох газруудаас 2-3 хүн
- е. Төрийн дипломат ёслолын газрын дарга
- ё. Холбогдох яам, агентлаг, төрийн байгууллагын зөвлөх мэргэжилтэн 3 хүртэлх хүн
- ж. Хамгаалалтын ажилтнууд
- з. Эмч, үйлчилгээний ажилтан 1-2 хүн
- и. Хэлмэрч

34.3. Монгол Улсын Ерөнхийлөгч гадаадад ажлын айлчлалаар явахад гэргий /нөхөр/ дагалдахгүй, харин албан ёсны төлөөлөгчид, ажлын хэсэг, хамгаалалт-үйлчилгээний албаны бүгд 12 хүртэлх хүн дагалдан явж болно.

35. Улсын Их Хурлын даргын айлчлал

35.1. Улсын Их Хурлын дарга гадаадад албан ёсны айлчлалаар явахад гэргий /нөхөр/, албан ёсны төлөөлөгчид, ажлын хэсэг, хамгаалалт-үйлчилгээний албаны ажилтнууд дагалдана.

35.2. Улсын Их Хурлын дарга гадаадад албан ёсны айлчлалаар явахад дагалдах хүмүүсийн тоо, нэрийг тухайн айлчлалын онцлог,



ажлын шаардлагыг үндэслэн тогтоох бөгөөд энэ тоо нь 16-аас хэтрэхгүй байна.

36. Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлал

36.1. Ерөнхий сайд гадаадад төрийн болон албан ёсны айлчлалаар явахад гэргий /нөхөр/, албан ёсны төлөөлөгчид, ажлын хэсэг, хамгаалалт-үйлчилгээний албаны ажилтнууд дагалдана.

36.2. Ерөнхий сайд гадаадад төрийн болон албан ёсны айлчлалаар явахад дагалдах хүмүүсийн тоо, нэрийг тухайн айлчлалын онцлог, ажлын шаардлагыг үндэслэн тогтоох бөгөөд энэ тоо нь 16-аас хэтрэхгүй байна.

36.3. Ерөнхий сайд гадаадад ажлын айлчлалаар явахад гэргий /нөхөр/ дагалдахгүй, харин албан ёсны төлөөлөгчид, ажлын хэсэг, хамгаалалт-үйлчилгээний албаны бүгд 12 хүртэлх хүн дагалдаж болно.

37. Гадаад хэргийн сайдын айлчлал

37.1. Гадаад хэргийн сайд /гэргий, нөхөр/ гадаадад айлчлал хийхэд Гадаад хэргийн яамны холбогдох нэгжийн удирдлага 2 хүртэлх хүн, холбогдох нэгжийн ажилтан 2 хүртэлх хүн, хэлмэрч зэрэг 6 хүртэлх хүн дагалдан явж болно.

37.2. Гадаад хэргийн сайдыг айлчлахад Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн дипломат ёслолын газрын дарга үдэж, угтана.

38. Гадаад улсын Ерөнхийлөгч, Парламентын дарга, Ерөнхий сайдын айлчлал

38.1. Гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын Монгол Улсад хийх айлчлалыг төрийн, албан ёсны, ажлын, хувийн гэж, Парламентын даргын айлчлалыг албан ёсны гэж ангилна.

38.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын урилгаар хоёр талын харилцааны асуудлаар хэлэлцээ хийх, баримт бичигт гарын үсэг зурах зорилгоор гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ын хийж байгаа айлчлалыг төрийн болон албан ёсны айлчлалд, Улсын Их Хурлын даргын урилгаар хийж байгаа гадаад улсын Парламентын даргын айлчлалыг албан ёсны айлчлалд хамааруулна.

38.3. Гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/ хоёр орны харилцаа, бүс нутгийн хийгээд олон улсын харилцааны асуудлаар зөвлөлдөх, санал солилцох, олон талын баримт бичигт гарын үсэг зурах, хурал зөвлөлтөөн, урлаг, соёл, спортын арга хэмжээ, түүхт ой,

тэмдэглэлт үйл явдалд оролцох, эмгэнэл илэрхийлэх болон дамжин өнгөрөхдөө тус улсад хийж буй айлчлалыг ажлын айлчлал гэж үзнэ.

38.4. Гадаад улсын Ерөнхийлөгч, Парламентын дарга, Ерөнхий сайдын Монгол Улсад хийх айлчлалын нэр, хөтөлбөрийг Гадаад хэргийн яам дипломат шугамаар хэлэлцэж тохирно.

38.5. Гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/ Монгол Улсад хийх хувийн айлчлалын үеэр угтах, үдэх болон тусгайлсан ёслолын арга хэмжээ зохиохгүй бөгөөд тэдгээрийг Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга угтаж, үднэ.

38.6. Гадаад улсын Ерөнхийлөгч, Парламентын дарга, Ерөнхий сайдын айлчлалын үеэр манай тал зардлыг нь харууцах төлөөлөгчдийн тоог харилцан адил байх зарчмын дагуу зохицуулна.

39. Гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын төрийн айлчлал

39.1. Төрийн айлчлалын угтах ёслолын ажиллагаа Буудлаас эхлэх бөгөөд энэ үед дараахь арга хэмжээг авна:

39.1.1. Буудалд байрлуулсан тугны ишний зүүн гар талынхад Монгол Улсын, баруун гар талынхад тухайн улсын Төрийн букоу тухайн Төрийн тэргүүний далбаа /цаашинд "Төрийн далбаа" гэх/-г мандуулж, Буудлын шатанд гудаслаг улаан хивс дэвсэн;

39.1.2. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ын зорчих зам /Чингисийн өргөн чөлөөнд Энх тайвны хаалганаас Төв шуудан хүртэл, Энх тайвны өргөн чөлөөнд Монгол Улсын Боловсролын их сургуулиас Энх тайван найрамдлын төлөө Монголын Холбоо хүртэл, галт тэргээр ирэх тохиолдолд Буудлаас Энх тайвны өргөн чөлөө, Олимпын өргөн чөлөөнд Гадаад хэргийн яамнаас төмөр замын гарц хүртэл/-ын хоёр хажуугийн баганад хоёр улсын Төрийн далбааг мандуулна;

39.1.3. гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ыг Монгол Улсын Гадаад хэргийн сайд /гэргий, нөхөр/, тухайн улсад суугаа Монгол Улсын Элчин сайд /гэргий, нөхөр/, Төрийн дипломат ёслолын газрын дарга нар угтана. Угтсан хүмүүс түүнийг буудаллах Харш, эсхүл зочид буудалд хүргэж ирнэ.

39.2. Гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ыг Д.Сүхбаатарын талбайд угтахад дараахь ёслолын арга хэмжээ болно:

39.2.1. Сүхбаатарын талбайн төв хэсэг дэх тугны баганын зүүн талынхад тухайн

улсын Төрийн далбаа, баруун талынхад Монгол Улсын Төрийн далбааг тус тус мандуулаа. Төрийн далбаануудын баруун талд Үлээвэр найрал хөгжим байрлаж, Гадаад улсын Ерөнхийлөгчийн төрийн айлчлалын үед Хүндэт харуулын тус бүр 24 цэрэг бүхий 3 салаа /Ерөнхий сайдын төрийн айлчлалын үед 2 салаа/, хоёр эгнээгээр зүүн тийш харж жагсана. Цагаан тугийг залсан байна;

39.2.2. гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ыг угтах Монголын талын албаны хүмүүс Хүндэт харуулын зүүн талд урагш харан баруун талаас төрийн ёслолын ахлалын дарааллаар зогсоно;

39.2.3. мандуулсан далбаануудын зүүн талд хоёр улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-д зориулж 3 x 2 м хэмжээтэй тавцан тусгайлан зассан байна. Уг тавцан зүүн, баруун талдаа нээлттэй байх бөгөөд бусад шонг хооронд нь улаан туузаар холбосон байна. Шонгийн өндөр нь 70 см байна;

39.2.4. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-тай анх уулзаж гар барих газар хивс дэвссэн байна. Гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ын хөлөглөн ирэх автомашинаас энэ хивс хүртэл, тэндээс ёслол үйлдэх бүх замын дагуу улаан өнгөтэй гудаслаг хивс үргэлжлүүлэн дэвсэн;

39.2.5. гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ыг зочид буудлаас нь Гадаад хэргийн сайд /гэргий, нөхөр/, Төрийн дипломат ёслолын газрын дарга залж ирнэ. Гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ын хөлөглөсөн машин Сүхбаатарын талбай руу орж ирэхэд Үлээвэр найрал хөгжим "Угтах марш" эгшиглүүлнэ. Зочны машин тогтоосон газарт ирж зогсоход Төрийн ордны хамгаалалтын албаны хоёр офицер гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/, түүний гэргий /нөхөр/-н талын хаалгыг нээн өгч ёслолно. Тэднийг угтахаар ирсэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын зүг явахад Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /гэргий, нөхөр/ мөн тэдний зүг алхаж хивсний голд уулзан гар барьж мөндэлнэ. Энэ үед монгол үндэсний хувцастай эрэгтэй, эмэгтэй хоёр хүүхэд амьд цэцгийн баглаа барина;

39.2.6. цэцгийн баглаа барьсны дараа Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ыг баруун гар талдаа дагуулан, тусгайлан зассан тавцанд очиж зогсоход Харуулын дарга угтан ирж "Монгол Улсад төрийн айлчлал хийж байгаа... улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/ Эрхэмсэг ноён /хатагтай/

... Таныг хүндэтгэн Хүндэт харуул жагссан. Харуулын дарга ..." гэж цэргийн цол, нэрээ хэлж айлтгал өргөнө. Хүндэт харуулын дарга байрандаа баруун гар тийш эргэж Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд болон гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/ өөд хараа шилжүүлэн зогсоход эхлээд тухайн улсын дараа нь Монгол Улсын Төрийн дууллыг тус тус эгшиглүүлнэ;

39.2.7. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын гэргий /нөхөр/, гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ын гэргий /нөхөр/-г баруун гартаа авч, тавцангийн зүүн талаас хоёр метр орчим зайд зогсох бөгөөд тэдний ард Гадаад хэргийн сайд гэргий /нөхөр/-н хамт зогссон байна;

39.2.8. Төрийн дуулал эгшиглэж дуусахад Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ын хамт тавцангаас бууж, Хүндэт харуулын зүг явна. Хүндэт харуулын дарга гурван алхмын зайд дагалдан явна. Хоёр орны төр, засгийн тэргүүн Хүндэт харуулын жагсаалын эхэнд залсан Цагаан туганд толгой мэхийн хүндэтгэл илэрхийлнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ыг эндээс эхлэн зүүн гар талдаа дагуулан, цааш явж жагсаалын дунд хэсэгт очоод Хүндэт харуул руу харж түр зогсоно. Гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/ Хүндэт харуултай "Дайчид аа, сайн байцаана уу" гэж мэндэлнэ. Хүндэт харуул "Амрыг эрвэ" гэж хариу мэндэлнэ;

39.2.9. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/ нар Хүндэт харуулын өмнүүр явж өнгөрөөд монголын талын албаны хүмүүсийн зүг эргэн явна. Хүндэт харуулын дарга дороо эргэж харуулын тийш алхана. Энэ үед Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын гэргий /нөхөр/, гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ын гэргий /нөхөр/, тэднийг угтсан Гадаад хэргийн сайд /гэргий, нөхөр/ араас нь дагалдан явж, угтагсадтай мөндэлнэ. Төрийн дипломат ёслолын газрын дарга монголын талын албаны хүмүүсийг гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-д танилцуулна;

39.2.10. Монголын талын албаны хүмүүсийн дараа гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ыг дагалдан яваа төлөөлөгчид Сүхбаатарын хөшөөний зүг харан баруун талаас төрийн ёслолын ахлалаар эгнэн зогсоно. Нөгөө талын ёслолын Албаны дарга еерийн талын төлөөлөгчид Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдад танилцуулна;

39.2.11. гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ыг дагалдан

яваа төлөөлөгчдийн дараа тухайн улсаас тус улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын гишүүд зогсоно. Тэднийг тухайн Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн танилцуулна. Үүгээр угтах ёслолын ажиллагаа өндөрлөнө.

39.2.12. Гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ыг Төрийн ордонд ирэх, явахад нь хаалга хүртэл гудаслаг улаан хивс, мөн хаалганы баруун гар талын баганад тухайн орны, зүүн гар талын баганад Монгол Улсын Төрийн далбааг мандуулна.

39.3. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд Төрийн ёслол хүндэтгэлийн өргөөнд гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ыг хүлээн авч, уулзалт хийх үед дараахь ёслолыг хийнэ:

39.3.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ыг Төрийн ёслол хүндэтгэлийн өргөөний баруун талд угтан мэндчилж, баруун хойморын суудалд урина. Ёслолын уулзалтад оролцох монголын талын албаны хүмүүс өргөөний зүүн талаар, гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ыг дагалдан яваа хүмүүс баруун талаар зассан суудлуудад сууна. Ёслолын уулзалтад оролцогсдыг цай, цагаан идээ, төрөл бүрийн ундаагаар зочилно. Ёслолын уулзалтыг албан ёсны хэлмэрч орчуулж, тэмдэглэл үйлдэнэ;

39.3.2. ёслолын уулзалтад оролцогсод Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ыг дагалдан өргөөний хоймороор нар зөв тойрч гарна.

39.4. Гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/ Монгол Улсад төрийн айлчлал хийх хугацаанд Засгийн газрын гишүүн, тухайн улсад суугаа Монгол Улсын элчин сайд /гэргий, нөхөр/, Төрийн дипломат ёслолын газрын дарга байнга дагалдана.

39.5. Гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ыг үдэхэд дараахь ёслол үйлдэнэ:

39.5.1. Монгол Улсад төрийн айлчлал хийж буй гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ыг Буудал руу хөдлөхөөс өмнө Гадаад хэргийн сайд /гэргий, нөхөр/ зочид буудалд үдэх уулзалт хийнэ;

39.5.2. гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ыг Гадаад хэргийн сайд /гэргий, нөхөр/ Буудалд дагалдан очиж, цэцгийн баглаа гардуулан үднэ;

39.5.3. Буудалд хоёр улсын Төрийн далбааг мандуулж, Буудлын талбайд гудаслаг улаан хивс дэвсэнэ;

39.5.4. гадаад улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ыг үдэх мордуулахад угтсан хүмүүс байлцана.

40. Гадаад улсын Төрийн тэргүүний албан ёсны болон ажлын айлчлал

40.1. Гадаад орны Төрийн тэргүүний албан ёсны айлчлалын үеэр Сүхбаатарын талбайд угтах ёслол үйлдэхгүй. Ёслолын бусад үйл ажиллагаа нь төрийн айлчлалынхтай адил байна.

40.2. Гадаад улсын Төрийн тэргүүний ажлын айлчлалын үеэр гудамжинд Төрийн далбаа өлгөхгүй, Сүхбаатарын талбайд угтах ёслол үйлдэхгүй. Ёслолын бусад үйл ажиллагаа нь албан ёсны айлчлалынхтай адил байна.

41. Гадаад улсын Парламентын даргын албан ёсны айлчлал

41.1. Гадаад улсын Парламентын дарга /гэргий, нөхөр/ Монгол Улсад албан ёсны айлчлалаар ирэх, буцахад Буудалд Монгол Улс болон тухайн улсын Төрийн далбааг мандуулж, Буудлын талбайд гудаслаг улаан хивс дэвсэнэ. Тэднийг Улсын Их Хурлын дэд дарга /гэргий, нөхөр/, Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга, Тамгын газрын гадаад харилцааны хэлтсийн дарга, ажилтнууд, Төрийн дипломат ёслолын газрын ажилтан угтаж, үднэ. Зочдод цэцгийн баглаа барина.

41.2. Монгол Улсад албан ёсны айлчлалаар ирсэн Парламентын дарга /гэргий, нөхөр/-ыг Буудал руу хөдлөхөөс өмнө Улсын Их Хурлын дэд дарга /гэргий, нөхөр/ зочид буудалд үдэх уулзалт хийнэ.

41.3. Парламентын даргыг угтсан хүмүүс Буудлаас үдэж, цэцгийн баглаа гардуулна.

41.4. Гадаад улсын Парламентын дарга албан ёсны айлчлал хийх хугацаанд Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга, эсхүл орлогч дарга, Гадаад харилцааны хэлтсийн дарга, ажилтан, Төрийн дипломат ёслолын газрын ажилтан дагалдана.

42. Гадаад улсын Засгийн газрын тэргүүний албан ёсны айлчлал

42.1. Монгол Улсад албан ёсны айлчлал хийх гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг угтахдаа энэхүү журмын 39 дүгээр зүйлд заасныг жишиг болгоно.



42.2. Гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг Монгол Улсын Ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын даргад бараалхуулж болно.

42.3. Гадаад улсын Засгийн газрын тэргүүнд Монгол Улсын Засгийн газрын гишүүн бераалхаж болно.

42.4. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн /гэргий, нөхөр/-ийг айлчлахад тухайн улсад суугаа Монгол Улсын алчин сайд /гэргий, нөхөр/, Төрийн дипломат ёслолын газрын дарга байнга дагалдана.

42.5. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн /гэргий, нөхөр/ Буудал руу хөдлөхөөс өмнө Монгол Улсын Гадаад хэргийн сайд /гэргий, нөхөр/ зочид буудалд очин үдэх уулзалт хийнэ.

42.6. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн /гэргий, нөхөр/-ийг угтсан хүмүүс Буудлаас үдэж, цэцгийн баглаа гардуулна.

43. Гадаад улсын Засгийн газрын тэргүүний ажлын айлчлал

43.1. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн ажлын айлчлалаар ирэхэд Буудалд Монгол Улс, тухайн улсын Төрийн далбааг мандуулж, Буудлын талбайд гудаслаг улаан хивс дэвсэнэ.

43.2. Албан ёсны яриа хэлэлцээнд монголын талыг тэргүүлж оролцох Засгийн газрын гишүүн гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг Буудалд угтаж, үднэ.

43.3. Гадаад улсын Засгийн газрын тэргүүнтэй уулзалт, хэлэлцээ хийх, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргад бараалхуулах, баримт бичигт үсэг зурах, түүнд зоог барихад энэ журмын 44.2.3-т заасан ёслолыг жишиг болгон баримтална.

44. Гадаад улсын Ерөнхийлөгч, Парламентын дарга, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ын айлчлалтай холбогдсон нийтлэг зүйл

44.1. Гадаад улсын Төр, засгийн тэргүүний төрийн айлчлал, албан ёсны айлчлал, Засгийн газрын тэргүүний албан ёсны айлчлалын үеэр тэдгээрийн хөлөглөн яваа унаанд хоёр улсын Төрийн далбааг мандуулна.

44.2. Гадаад улсын Ерөнхийлөгч, Парламентын дарга, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ын айлчлалын үеэр тус улсын Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд албан ёсны хэлэлцээ, уулзалт хийж, зоог барина.

44.3. Хэлэлцээ хийх, баримт бичигт гарын үсэг зурах, зоог барихад хоёр улсын Төрийн далбааг мандуулна.

44.4. Гадаад улсын Ерөнхийлөгч, Парламентын дарга, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-тай хийх хэлэлцээ, уулзалт, зоогийн үеэр албан ёсны хэлмэрч, тэмдэглэл хөтлөх ажилтан байна.

44.5. Гадаад улсын Ерөнхийлөгч, Парламентын дарга, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ын айлчлалын үеэр гэргий /нөхөр/-д нь зориулан тусгай хөтөлбөр гаргана.

44.6. Гадаад улсын Ерөнхийлөгч, Парламентын дарга, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ын айлчлалын хөтөлбөрийг монгол, тухайн улсын буюу харилцан тохиролцсон аль нэг түгээмэл гадаад хэлээр хэвлүүлнэ.

44.7. Гадаад улсын Ерөнхийлөгч, Парламентын дарга, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ын айлчлалын үеэр бие хамгаалагч, тусгай зориулалтын автомашин /хуягласан/ гаргана. Зочдын аюулгүй байдалтай холбоотой асуудлыг Төрийн тусгай хамгаалалтын газар хариуцна.

44.8. Гадаад улсын Ерөнхийлөгч, Парламентын дарга, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ын айлчлалын үеэр манай тал зардлыг нь хариуцах төлөөлөгчийн тоог тогтоохдоо харилцан адил байх зарчмыг баримтална.

44.9. Гадаад улсын Ерөнхийлөгч, Парламентын дарга, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ын хөлөглөх унаа, ёслол, хамгаалалтын автомашинд холбооны техник хэрэгсэл суурилуулна.

44.10. Гадаад улсын Ерөнхийлөгч, Парламентын дарга, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-ын байрлах Харш буюу зочид буудлын өмнө тухайн улсын Төрийн далбааг мандуулна.

44.11. Гадаад улсын Ерөнхийлөгч, Парламентын дарга, Ерөнхий сайд /Эзэн хаан, Хатан хаан/-д монгол үндэсний агуулга бүхий бэлэг, дурсгалын зүйл гардуулна.

45. Гадаад улсын Гадаад хэргийн сайдын айлчлал

45.1. Гадаад хэргийн сайдын Монгол Улсад хийх айлчлалыг төр, засгийн өндөр албан тушаалтны айлчлалд хамруулах бөгөөд албан ёсны болон ажлын айлчлал гэж ангилна.

45.2. Буудалд угтах, үдэхэд хоёр улсын Төрийн далбааг мандуулж, Буудлын талбайд гудаслаг улаан хивс дэвсэнэ.

45.3. Гадаад хэргийн сайд /гэргий, нөхөр/-ыг Төрийн нарийн бичгийн дарга /гэргий, нөхөр/, Гадаад хэргийн яамны холбогдох газрын захирагч,

Төрийн дипломат ёслолын газрын дарга угтана. Угтсан хүмүүс Гадаад хэргийн сайдыг зочид буудалд нь хүргэнэ. Буудлын өмнө тухайн улсын Төрийн далбааг мандуулна.

45.4. Айлчлалын хугацаанд Гадаад хэргийн яамны холбогдох газрын захирал, Төрийн дипломат ёслолын газрын ажилтан дагалдана.

45.5. Монгол Улсын Гадаад хэргийн сайд зочилж байгаа Гадаад хэргийн сайдтай хэлэлцээ хийнэ. Хэлэлцээний ширээнд хоёр улсын Төрийн далбаа, хэлэлцээнд оролцогчдын нэрс, бичгийн хэрэгсэл тавьсан байна.

45.6. Гадаад хэргийн сайдын айлчлалын үеэр Гадаад хэргийн яамны байрны гол хаалганы баруун, зүүн талд хоёр улсын Төрийн далбааг мандуулна.

45.7. Гадаад хэргийн сайдыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдад бараалхуулж болно.

45.8. Гадаад хэргийн сайд гадаад улсын Гадаад хэргийн сайд, түүний гэргий /нөхөр/-т үндэсний дурсгалын зүйл өгч болно.

45.9. Гадаад хэргийн сайд /гэргий, нөхөр/ Буудал руу хөдлөхөөс өмнө Төрийн нарийн бичгийн дарга /гэргий, нөхрийн хамт/ үдэлтийн уулзалт хийнэ.

45.10. Гадаад хэргийн сайдыг угтсан хүмүүс Буудлаас үдэж, цэцгийн баглаа барина.

46. Нэгдсэн үндэстний байгууллага, түүний төрөлжсөн байгууллагын тэргүүний айлчлал

46.1. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга /гэргий, нөхөр/-ын айлчлалыг хэрэгжүүлэхдээ энэхүү журмын 45 дугаар зүйлийг жишиг болгоно.

46.2. НҮБ-ын төрөлжсөн бусад байгууллагуудын тэргүүний айлчлалыг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний түвшинд зохион байгуулах бөгөөд Төрийн дипломат ёслолын газар эрхлэн хэрэгжүүлнэ.

47. Гадаад улсын Хунтайж, Гүнж нарын айлчлал

47.1. Гадаад улсын төрийн тэргүүний Угсаа залгамжлах Хунтайж, Гүнж айлчлахад энэхүү журмын 39.1.1, 39.3.1, 39.3.2 дахь заалтуудыг мөрдөнө.

47.2. Угсаа залгамжлах Хунтайж, Гүнжийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын

дарга, Төрийн дипломат ёслолын газрын дарга нар уугтаж үдэн, байнга дагалдана.

47.3. Гадаад улсын Хунтайж, Гүнжийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Гадаад бодлогын зөвлөх, Төрийн дипломат ёслолын газрын ажилтан уугтаж үдэн, байнга дагалдана.

47.4. Хунтайж, Гүнжийг айлчлуулах бусад ёслол нь энэхүү журмын 47.1-д заасантай адил байна.

47.5. Энэхүү зүйлийн 47.2, 47.3-т заасан албан тушаалтнууд тухайн зочноо Буудал руу хөдлөхөөс өмнө зочид буудалд нь очиж, уулзалт хийнэ.

48. Холбооны улсын бүрэлдэхүүнд багтдаг Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Парламентын дарга, Ерөнхий сайдын айлчлал

48.1. Холбооны улсын бүрэлдэхүүнд багтдаг Бүгд Найрамдах Улсын /БНУ/ төр, засаг, парламентын тэргүүн болон тэдгээртэй адилтгах албан тушаалтан Монгол Улсад айлчлахад Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газар болон Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга тус тусын чиглэлээр Төрийн дипломат ёслолын газрын ажилтны хамт уугтаж, үднэ. Тэднийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдад тус тус бараалхуулж болно.

48.2. Монгол Улсын Засгийн газрын гишүүн Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдад, Улсын Их Хурал дахь тухайн Холбооны улсыг хамаарах Парламентын бүлгийн гишүүн Парламентын даргад тус тус зоог барьж болно.

48.3. Хэлэлцээ, зоогийн танхимд Монгол Улс, тухайн Холбооны улс болон Бүгд Найрамдах Улсын Төрийн далбааг мандуулж болно. Харин Монгол Улс, тухайн Бүгд Найрамдах Улсын Төрийн далбааг зэрэгцүүлэн хэрэглэж үл болно.

49. Гадаадын зочид, төлөөлөгчидтэй уулзах

49.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд, Үндсэн хуулийн цэцгийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурорыг гадаадын албан ёсны зочин, төлөөлөгчидтэй уулзуулах асуудлыг Төрийн дипломат ёслолын газар тухайн төлөөлөгчдийн зэрэг зиндааг харгалзан шийдвэрлэж байна.

49.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд тус улсад суугаа

гадаадын Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, гишүүдтэй харилцах асуудлыг Төрийн дипломат ёслолын газар эрхлэн гүйцэтгэнэ.

49.3. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурорыг гадаадын дээд, өндөр хэмжээний төлөөлөгчид болон Дипломат төлөөлөгчдийн газрын тэргүүн нартай уулзахаад байх хүмүүс болон хэлмэрч, тэмдэглэл хөтлөх буюу хэвлэл мэдээллийн албаны ажилтнуудыг Төрийн дипломат ёслолын газар зохицуулах бөгөөд Төрийн ёслолын албатай зөвшилцөн.

49.4. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурортой гадаадын үйлдвэр, худалдаа, нам болон төрийн бус байгууллагуудын шугамаар ирсэн зочин, төлөөлөгчдийг уулзуулах асуудлыг Төрийн ёслолын алба, Төрийн дипломат ёслолын газраар дамжуулан шийдвэрлэнэ. Тухайн зочин, төлөөлөгчдийг урьж ирүүлсэн байгууллага, хүмүүс, зочид, төлөөлөгчдийн ирсэн зорилго, тэдгээрийн талаархи товч танилцуулга, Монгол Улсад хүлээн авах байгууллага болон хүмүүсийн талаар 7 хоногийн өмнө бичгээр Төрийн дипломат ёслолын газарт мэдэгдсэн байна. Төрийн дипломат ёслолын газар нь зочин, төлөөлөгчдийг уулзуулах эсэх, ямар зэрэг зиндааны албан тушаалтантай уулзуулах асуудлыг тус тус шийдвэрлэнэ.

49.5. Төрийн ёслолын алба Төрийн ордонд болох уулзалтын цаг, байр, үйлчилгээг зохицуулан холбогдох албадад мэдээлэх, зочдыг угтах, үдэх ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

49.6. Төрийн ёслолын алба, Төрийн дипломат ёслолын газар нь төрийн ёслолын үйл ажиллагаа, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын уулзалт, гадаадад хийх айлчлал, гадаадын дээд хэмжээний төлөөлөгчдийн айлчлалыг гэрэл зургаар баримтжуулж жал бүр Үндэсний төв архивт шилжүүлнэ.

49.7. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд гадаадын төр, засгийн өндөр албаны хүмүүстэй утсаар ярихад Гадаад хэргийн яамны холбогдох газрын ажилтан тэмдэглэл хөтөлж, тэмдэглэлийн хувийг хүргүүлнэ.

49.8. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд гадаадын зочин, төлөөлөгчдийг түлээн авч уулзахад оролцох хүмүүсийн тоог Төрийн ёслолын алба, Төрийн дипломат ёслолын газар зөвшилцөн тогтооно.

49.9. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдаас ярилцлага авах асуудлыг тэдгээрийн хэвлэл мэдээллийн албад, Гадаад хэргийн яамны хэвлэл мэдээллийн хэлтэс хариуцан зохицуулна.

50. Төрийн ёслолын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх

50.1 Энэ журамд заасан дипломат ёслолын аливаа арга хэмжээг нийтэд мэдээлэх, түүнд гадаад, дотоодын хэвлэл мэдээллийн ажилтнуудыг хэрхэн хамруулахыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай Гадаад хэргийн яам зөвшилцөн зохион байгуулна.

50.2 Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайд гадаадад айлчлал хийх тухай товч мэдээг уг айлчлал эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө хэвлэлд нийтэлж, айлчлахаар мөрдсөн, айлчлалын явц, эргэж ирсэн талаар тухай бүр мэдээлнэ. Айлчлал хийхэд хэвлэл мэдээллийн болон баримтат киноны хэсэг дагалдаж болно.

50.3. Манай улсад гадаад улсын төр, засгийн тэргүүн айлчлал хийх тухай мэдээг айлчлал эхлэхээс 10-аас доошгүй хоногийн өмнө, түүнчлэн тэдний гэрэл зураг, намтрыг айлчлал эхлэхээс 1 хоногийн өмнө буюу айлчлал эхлэх өдөр нийтэлнэ. Айлчлалын хөтөлбөрт заасан арга хэмжээний үеэр хэвлэлийн хэсэг дагалдан сурвалжилж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухай бүр мэдээлж байна.

50.4. Гадаад дотоодын хэвлэл мэдээллийн хэсэг, гэрэл зурагчид, киноны болон телевизийн зураглаачдыг хэлэлцээ, хүндэтгэлийн зоог зэрэг зарим арга хэмжээний эхэнд 3 минутаас илүүгүй хугацаанд багтаан сурвалжлага хийгч болно.

50.5. Монгол Улсад айлчлалаар хүрэлцэн ирэх гадаад улсын төр, засгийн тэргүүнийг дагалдан яваа хэвлэлийн хэсгийн үйл ажиллагааг Гадаад хэргийн яам эрхлэн зохион байгуулна.

50.6. Гадаад улсаас тус улсад суух анхны Элчин сайд томилогдон ирэхэд баримтат кино зураг авч Гадаад хэргийн төв архивт хадгална.

51. Бусад зүйл

51.1. Монгол Улсын төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, төрийн ёслолын журамтай холбогдуулан хүлээсэн үүргээ ёсчлон биелүүлж, энэ талаар Төрийн ёслолын алба, Төрийн дипломат ёслолын газартай хамтарч ажиллах үүрэгтэй.



51.2. Гадаад хэргийн яам энэ журамд заасан дипломат ёслолын үйл ажиллагааг тухайн цаг үеийн онцлог, гадаад улс, олон улсын байгууллагын ёслолын журам, олон улсын харилцааны тухайн үеийн практикт нийцүүлж зохих шийдвэр гаргуулан өөрчлөн уян хатан хэрэглэж болно.

51.3. Энэ журамд заагдаагүй айлчлал, бусад арга хэмжээг уг журмын жишиж болох төрөл зүйлтэй адилтган зохицуулна.

51.4. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайд,

гадаад улсын төр, засгийн тэргүүний болон Гадаад хэргийн сайдын айлчлал, Монгол Улсын болон гадаад улсын Элчин сайд нар Жуух барих, энэхүү журмын 34-36 дугаар зүйлд дурдсан айлчлал, түүнчлэн 49 дүгээр зүйлд дурдсан зарим чухал уулзалтын гэрэл зургийг Гадаад хэргийн яамны Хэвлэл мэдээллийн хэлтэс Гадаад хэргийн төв архивт, Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хуралдаан, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүд тангараг өргөх, түүнчлэн үндэсний ёслолын бусад чухал үйл явдлуудын гэрэл зургийг холбогдох хэвлэл мэдээллийн албад Үндэсний төв архивт тус тус шилжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 110

Улаанбаатар хот

Хилийн чанадад байгаа монгол улсын иргэдэд туслах сангийн дүрэм, сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.4.16, 26.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Сангийн сайд Ч.Улаан, сангийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Гадаад хэргийн сайд С.Оюун нарт тус тус үүрэг болгосугай.

1. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрмийг 1 дүгээр, сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтын ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	С.БАЯР
САНГИЙН САЙД	Ч.УЛААН
ГАДААД ХЭРГИЙН САЙД	С.ОЮУН

2. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах санд төсвөөс олгох хөрөнгийг жил бүр хянаж улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг

Засгийн газрын 2008 оны 110 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ТУСЛАХ САНГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

2.1.1. улсын төсвийн хөрөнгө;

1.1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.4.16-д заасан Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан (цаашид "Сан" гэх)-гийн хөрөнгийг зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү дүрмийг дагаж мөрдөнө.

2.1.2. гадаад улс, олон улсын байгууллага болон гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс өгсөн буцалтгүй тусламж, хандив.

1.2. Сангийн үйл ажиллагаа нь Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

2.2. Гадаад хэргийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага улсын төсвөөс Санд олгох хөрөнгийн хэмжээг өмнөх онд Санд төвлөрүүлсэн орлого болон гарсан зардлын гүйцэтгэл, жилийн эцсийн үлдэгдлийг харгалзан төлөвлөнө.

Хоёр. Сангийн эх үүсвэр

2.1. Сангийн хөрөнгө нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ.

2.3. Гадаад хэргийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын Санд төвлөрүүлэхээр төлөвлөсөн хөрөнгийн хэмжээг санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны

төв байгууллага Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд заасан журмын дагуу хянаж, тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэл болон улсын төсвийн төсөлд тусгана.

2.4. Сангийн хөрөнгийг төрийн сан дахь гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд байршуулна.

Гурав. Сангийн удирдлага, зохион байгуулалт

3.1. Сангийн удирдлага нь 7 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус Сангийн зөвлөл байна.

3.2. Гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Сангийн зөвлөлийн дарга байна. Сангийн зөвлөл нь дэд дарга, гишүүд, нарийн бичгийн даргатай байна.

3.3. Сангийн зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байх бөгөөд 5-аас доошгүй гишүүн оролцсоноор хурал хүчинтэйд тооцогдоно.

3.4. Сангийн зөвлөлөөр хэлэлцсэн асуудлыг Зөвлөлийн 4-өөс доошгүй гишүүний саналаар шийдвэрлэнэ. Хурлын тэмдэглэлд Сангийн зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

3.5. Сангийн зөвлөл нь дараахь эрх, үүрэг хүлээнэ:

3.5.1. Сангийн үйл ажиллагааг удирдлагаар хангах, хяналт тавих;

3.5.2. тусламж хүссэн өргөдлийг холбогдох дипломат төлөөлөгчийн газрын саналын хамт хянаж, тусламж үзүүлэх эсэхийг шийдвэрлэх;

3.5.3. шаардлагатай бол гадаад, дотоодын байгууллага, иргэдээс нэмэлт мэдээлэл, тодруулга гаргуулж авах;

3.5.4. Сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын талаар гадаад хэргийн болон санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад санал тавих;

3.5.5. Сангийн хөрөнгийн зарцуулалт, иргэдэд үзүүлэх тусламжийн талаар

дипломат төлөөлөгчийн газарт чиглэл өгөх, гүйцэтгэлийг нь хянах;

3.5.6. олон улсын байгууллага, гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, бусад сантай хамтран ажиллах;

3.5.7. Сангийн хөрөнгийг зориулалт бусаар ашигласан байгууллага, албан тушаалтанд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх асуудлаар холбогдох байгууллагад санал оруулж шийдвэрлүүлэх.

3.6. Сангийн ажлын албаны үүргийг гадаад хэргийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал хариуцсан нэгж гүйцэтгэнэ.

3.7. Дипломат төлөөлөгчийн газар нь иргэдээс тусламж хүссэн өргөдөл хүлээн авч энэхүү дүрмийн "Дөрөв"-т заасны дагуу хянан шалгаж, нөхцөл, шаардлагыг хангаж байгаа өргөдлийг өөрийн саналын хамт Сангийн зөвлөлд хүргүүлнэ.

3.8. Шаардлагатай бол дипломат төлөөлөгчийн газар нь суугаа болон хавсран суугаа орны байгууллага, иргэдээс нэмэлт мэдээлэл, тодруулга гаргуулж авна.

3.9. Дипломат төлөөлөгчийн газар нь Сангийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн өргөдөл гаргасан иргэнд тусламж үзүүлнэ.

3.10. Дипломат төлөөлөгчийн газар нь иргэдэд үзүүлсэн тусламжийн талаар Сангийн зөвлөлд мэдээлэл өгч, холбогдох баримт материалыг хүргүүлнэ.

Дөрөв. Сангийн хөрөнгийг зарцуулах нөхцөл, шаардлага

4.1. Сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17.2-т заасан зориулалтаар зарцуулна.

4.2. Сангийн хөрөнгөөс хилийн чанадад байгаа Монгол Улсын төлбөрийн чадваргүй иргэнд тусламж дэмжлэг үзүүлнэ.

4.3. Дараахь тохиолдолд Сангийн хөрөнгөөс тусламж олгоно:

4.3.1. хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарилыг эх оронд нь авчрах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл садан нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах;

4.3.2. хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, алан хядах ажиллагаа, зэвсэгт мөргөлдөөнд ертсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, сэтгэцийн өвчтэй болсон, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаах;

4.3.3. хилийн чанадад хорих ял эдэлж байгаад, эсхүл албадан саатуулагдаж байгаад суллагдсан иргэнийг эх оронд нь буцаах;

4.3.4. гэмт хэргийн улмаас хохирсон буюу эд хөрөнгөө хаяж гээгдүүлсний улмаас төлбөрийн чадваргүй болсон иргэнийг эх оронд нь буцаах;

4.3.5. энэхүү дүрмийн 4.3.1-4.3.4-т заасан иргэний үндэсний гадаад паспортын хугацааг сунгах, буцах үнэмлэх олгох, эх оронд нь буцаахтай холбогдсон бусад үйлчилгээ үзүүлэх;

4.3.6. хилийн чанадад гэмт хэргийн улмаас хохирсон иргэнтэй холбоотой асуудлыг тухайн улсын холбогдох хууль хяналтын байгууллагаар хянуулах, эрх ашгийг нь хамгаалахад шаардагдах өмгөөлөгч, орчуулагчийг хөлслөх;

4.3.7. хилийн чанадад хорих ял эдэлж байгаа иргэнийг дипломат төлөөлөгчийн газраас эргэх.

4.4. Сангийн хөрөнгөөс үзүүлэх тусламжийн хэмжээг дараахь байдлаар тодорхойлж тооцно:

4.4.1. гарсан бодит зардлаар;

4.4.2. энэхүү дүрмийн 4.3.1-4.3.4-т заасан иргэнийг эх оронд нь буцаах замын зардлыг тухайн үеийн хамгийн хямд, дөт замаар буцаах тээврийн зардлаар;

4.4.3. энэхүү дүрмийн 4.3.5-д заасан тусламжийн хэмжээг Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, тухайн улсын визний хураамж, холбогдох дипломат төлөөлөгчийн газрын зардлын гүйцэтгэлээр.

4.5. Энэхүү дүрмийн 4.3.5-д заасан тохиолдолд тухайн иргэн үндэсний гадаад паспорт эзэмших, хадгалах журмыг зөрчсөн байвал Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан торгуулийг Сангийн хөрөнгөөс төлнө.

Тав. Өргөдөл гаргах, хянан шийдвэрлэх ажиллагаа

5.1. Сангийн хөрөнгөөс тусламж хүссэн өргөдлийг холбогдох дипломат төлөөлөгчийн газарт гаргана.

5.2. Өргөдлийг дараахь байдлаар гаргана:

5.2.1. иргэн биечлэн болон баталгаат шуудангаар;

5.2.2. эрүүл мэндийн буюу хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас өөрийн биеэр өргөдөл гаргах боломжгүй иргэний өргөдлийг түүний итгэмлэгдсэн төлөөлөгч;

5.2.3. энэхүү дүрмийн 4.3.1-д заасан тохиолдолд өргөдлийг түүний гэр бүлийн гишүүн, хууль ёсны төлөөлөгч, эсхүл тэдний итгэмжлэгдсэн төлөөлөгч, сонирхсон байгууллага болон консулын албан тушаалтан.

5.3. Өргөдөлд дараахь баримт бичгийг хавсаргана:

5.3.1. үндэсний гадаад паспорт, иргэний үнэмлэх зэрэг иргэний харьяаллыг тодорхойлох баримт бичиг, эсхүл тэдгээрийн баталгаажуулсан хуулбар;

5.3.2. тусламж үзүүлэх шаардлагатай болохыг нотлох суугаа орны цагдаа, шүүх эмнэлэг зэрэг зохих байгууллага, иргэний тодорхойлолт, мэдүүлгийн эх хувь;

5.3.3. энэхүү дүрмийн 4.3.1-4.3.4, 4.3.6-д заасан тохиолдолд төлбөрийн чадваргүйг нотлох өрхийн ам бүл, орлогын хэмжээний талаар харьяалах баг, хороо, аймаг, нийслэлийн захиргааны байгууллагаас уламжлан авсан тодорхойлолт.

5.4. Дипломат төлөөлөгчийн газар өргөдлийг хүлээн авч энэхүү дүрмийн "Дөрөв"-т заасан нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянан шалгаж, шаардлага хангаж байгаа бол ажлын 3 хоногийн дотор өргөдлийг өөрийн саналын хамт Сангийн зөвлөлд цахим шуудангаар мэдүүлнэ.

5.5. Сангийн зөвлөл өргөдлийг дипломат төлөөлөгчийн газраас хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ.

Зургаа. Сангийн хөрөнгийг зарцуулах

6.1. Сангийн зөвлөлөөс шийдвэр гарснаас хойш ажлын 2 хоногт багтаан Сангаас хөрөнгө гаргаж холбогдох дипломат төлөөлөгчийн газрын дансанд шилжүүлнэ.

6.2. Сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.

Долоо. Сангийн гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавих

7.1. Сангийн зарцуулалтын тайланг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 30.1-д заасны дагуу хагас, бүтэн жилээр гаргана.

7.2. Сангийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.

7.3. Гадаад хэргийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Сангийн хөрөнгийн зарцуулалтын жилийн эцсийн тайланг аудитын дүгнэлтийн хамт тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор хэвлэлд нийтэлж нийтэд мэдээлнэ.

7.4. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 64 дүгээр зүйлд заасан журмын дагуу Сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт, шалгалт хийнэ.

Засгийн газрын 2008 оны 110 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ТУСЛАХ САНГИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга - Гадаад хэргийн сайд

-Гадаад хэргийн яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал;

Дэд дарга - Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Мэргэжлийн боловсролын газрын дарга.

Гишүүд - Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн (тохиролцооноор);

-Гадаад хэргийн яамны Санхүү, эдийн засгийн газрын заирал;

Нарийн бичгийн дарга - Гадаад хэргийн яамны Консулын газрын захирал.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 111

Улаанбаатар хот

Үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

"Монгол Улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлогыг батлах тухай" Улсын Ит Хурлын 2007 оны 45 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон төсөвт жил бүр тусган хэрэгжүүлэхийг Сангийн сайд Ч.Улаан, Эрүүл мэндийн сайд Б.Батсэрээдэнэ нарт даалгасугай.

1. Монгол Улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлогыг 2008-2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтын ёсоор баталсугай.

3. Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг жил бүрийн IY улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Эрүүл мэндийн сайд Б.Батсэрээдэнэ үүрэг болгосугай.

2. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг хянан тооцож эдийн засаг,

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД**

Б.БАТСЭРЭЭДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ДОНОРЫН ЦУС, ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ 2008-2015 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа /он/	Хариуцан хэрэгжүүлэгч байгууллага
	Зорилт 1. Эрүүл мэндийн байгууллагыг аюулгүй, чанарын баталгаатай донорын цус, цусан бүтээгдэхүүнээр жигд, тэгш, хүртээмжтэй бүрэн хангана		
1	Эрүүл мэндийн салбарын хүний нөөц, материаллаг баазад тулгуурлан цусны асуудал хариуцсан байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох	2008-2009	ЭМЯ
2	Цус, цусан бүтээгдэхүүн /цус цусан бүтээгдэхүүн/ үндэсний стандартыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх	2008-2014	ЭМЯ, Цус салбарт, судлалын үндэсний төв, Стандартчилал хэмжил зүйн төв ЭМЯ, ЦССУТ
3	Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зохиистой үйл ажиллагааг мөрдүүлж (GMP), олон улсын стандартын түвшинд хүргэх	2010-2015	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
4	Донор элсүүлэх, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, шинжилгээ, цус салбарт зэрэг цусны асуудал хариуцсан байгууллагын үйл ажиллагааг улсын хэмжээнд цахим бүртгэлд шилжүүлэх, хүчин чадал бүхий тоног төхөөрөмжөөр бүрэн хангах	2008-2009	ЭМЯ, ЦССУТ
5	Цусны асуудал хариуцсан байгууллагын чанарын бодлогыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх	2008-2015	ЭМЯ, ЦССУТ
6	Цусны асуудал хариуцсан байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх стандарт ажиллагааны аргачлал /SOPS-ыг шинэчлэн боловсруулж түгээх	2008-2010	ЭМЯ ЦССУТ
7	Цус салбарт зэрэг дамжих халдаар илрүүлэх болон цусны дархлааг судлалын чанарын гадлаад үнэлгээнд хамрагдах	2008-2015	ЭМЯ, ДЭМБ ЦССУТ
8	"Цусны сонор сэрэмжийн хөтөлбөр" боловсруулж улсын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудад хэрэгжүүлэх	2009-2015	ЭМЯ, ЦССУТ ДЭМБ
9	Зонхилон тохиолдох өвчин эмгэгийн үед цус, цусан бүтээгдэхүүн хэрэглэх удирдамж боловсруулах	2008	ЭМЯ, ЦССУТ ДЭМБ
10	Цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, зохиистой хэрэглээний талаархи дүрэм, журам, удирдамж, гарын авлага, стандартуудыг хэвлүүлэн түгээх	2008-2010	ЭМЯ ЦССУТ ДЭМБ
	Зорилт 2. Гамшгийн үед шаардагдах цус, цусан бүтээгдэхүүний найдвартай, аюулгүй, хүрэлцээтэй нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангана		
11	Онцгой байдал, гамшгийн үед цус, цусан бүтээгдэхүүн болон тэдгээрийг орлох бэлдмэлээр найдвартай хангаж байгаа байдлад үнэлгээ өгч, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах	2008	ЭМЯ, ОБЕГ МУЗН БХЯ
12	Гамшгийн үед хэрэглэх цус, цусан бүтээгдэхүүн болон тэдгээрийг орлох бэлдмэлний нөөцийг бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусгах	2008-2015	ЭМЯ, БХЯ ОБЕГ БХЯ СЯ
13	Гамшгийн үед хун амлас донон дайчлах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө, ажиллах журмыг боловсруулах, сургалт, дадлага хийх	2008-2009	ЭМЯ, БХЯ, ОБЕГ нийслэл, аймаг болон дүүргийн ЗДТ

14	Гамшгийн үед төв орон нутгийн цусны асуудал хариуцсан байгууллагын ажиглах журам боловсруулж мөрдүүлэх	2008-2009	ЭМЯ, ОБЕГ, МУЗН Аймаг, нийслэлийн Засаг дарга
Зорилт 3. Донорын хөдөлгөөнийг олон улсын зарчимд нийцүүлэн өргөжүүлж, сургалт, сурталчилгааны ажилд эрүүл мэндийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, иргэний орлоцгоо нэмэгдүүлнэ			
15	Донорын хөдөлгөөн зохион байгуулсан байгууллага, иргэн болон цусаа өгсөн донорыг урамшуулах, алдаршуулах ажил зохион байгуулах	2008-2009	ЭМЯ, Төрийн бус байгууллага, ЦССУТ
16	Шийдвэр гаргагч нарын түвшинд донорын хөдөлгөөнийг дэмжих чиглэлээр уулзалт зохион байгуулах	2008	ЭМЯ, БХЯ, ХЗДХЯ, ОБЕГ, МУЗН, Монголын оюутны холбоо
17	Хүн амын дунд цусны донорын талаархи мэдлэг хандлагыг судалж, үнэлгээ өгөх	2008, 2012	ЭМЯ, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн БШШУЯ, МУЗН
18	Үндэсний болон орон нутгийн түвшинд донорын талаархи мэдлэг олгох сургалт, сурталчилгааг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон сурталчилгааны бүх хэлбэрийг ашиглан тогтмол явуулах, энэ чиглэлээр төсөл, хөтөлбөр боловсруулан эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх	2008-2015	ЭМЯ, ТББ, МУЗН Аймаг нийслэлийн ЗДТГ
19	Донорын сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах сургагч багш нарыг бэлтгэх сургалт зохион байгуулах	2008	ЭМЯ, ТББ
20	Сургалт сурталчилгааны ажлын материаллаг баазыг бэхжүүлэх чиглэлээр гадаад орон, олон улсын байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	2008-2015	ЭМЯ, ДЭМБ болон бусад байгууллага
Зорилт 4. Донорын цус, цусан бүтэцдэхүүнийг шинжлэх, үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэхэд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ			
21	Цусны донорыг бүртгэх, цус цусан бүтэцдэхүүнийг үйлдвэрлэх, хадгалах, түгээх зэрэг цусны асуудал хариуцсан байгууллагын үйл ажиллагааг үйлдүүлсэн дотоод сүлжээ, програмитай болох	2008-2010	ЭМЯ, ЦССУТ
22	Цусны асуудал хариуцсан байгууллагын эмч, ажилчдыг программ хангамжийг ашиглах чиглэлээр сургалтад хамруулах	2008-2009	Цус салбарт судлалын үндэсний төв, ЭМЯ
23	Цус салбарт, судлалын үндэсний төвд шинэ технологи нэвтрүүлэх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх замаар цусны өндөр идэвхитэй бэлдмэл үйлдвэрлэх, хадгалах, шинжлэхэд шаардлагатай материаллаг баазтай болох	2008-2010 2008-2015	СЯ, ЭМЯ СЯ, ЭМЯ
24	Бүсийн түвшинд сийвэгийн бэлдмэлээр хангах боломжийг бүрдүүлэх зорилгоор шинэ техник, технологийг нэвтрүүлэх		
25	Аймгийн түвшинд цус цусан бүтэцдэхүүнээр өөрийн хэрэгцээг хангах зорилгоор үе шаттайгаар тоног төхөөрөмжөөр хангах	2008-2015	Аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газар
26	Цус цусан бүтэцдэхүүний чанарын хяналтын тогтолцоог сайжруулах	2008-2010	ЦССУТ ЭМЯ
27	Сумдыг түргэчилсэн оношуур болон цус орлох бэлдмэлээр хангах ажлыг Цус салбарт, судлалын үндэсний төвөөр гүйцэтгүүлэх	2008-2015	ЭМЯ, ЦССУТ

28	Цус салбарт судлалын үндэсний төвийн лабораторийг нь ховор бүлгийн цусны шинжилгээ хийх чадвартай болгох	2008-2010	ЭМЯ ЦССУТ
29	Бүсийн оношилгоо эмчилгээний төв болон аймгийн салбар станцыг цусны дархлал судлалын зарим шинжилгээ хийдэг чадвартай болгох	2008-2015	ЭМЯ
30	Сумдын түвшинд цуглуулсан цусны нэгж бүрт АВО бүлэг, резус хүчин зүйл тодорхойлох, сэлбэлт бүрт хувийн тохирооны шинжилгээг хийдэг болгох	2008-2015	ЭМЯ, ЦССУТ
31	Цусны асуудал хармуцсан байгууллагад ажиллах эмч, мэргэжилтнийг үйлдвэрлэлийн трансфузиологич мэргэжлээр сурган мэргэшүүлэх, мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг холбогдох байгууллагатай хамтран боловруулах	2010-2015	ЭМЯ БСШУЯ ЦССУТ
32	Клиникийн болон нэгдсэн эмнэлэгт эмнэл зүйн трансфузиологич бэлтгэх давтан сургалтын хөтөлбөр боловсруулах	2008-2015	ЭМЯ, БСШУЯ ЦССУТ
33	"Цусны аюулгүй байдлыг хангах нь" сэдэвт сургалтад цусны асуудал хармуцсан байгууллагын бүх ажилтнуудыг ээлж дараатай хамруулах	2008-2015	ЦССУТ
34	Цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг, түүний чанарт хийх хяналт, гадаад үнэлгээний талаар сургалт зохион байгуулах	2009-2015	ЦССУТ, ДЭМБ, ЭМЯ
35	Эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа лабораторийн их эмч, лаборант нарыг цусны аюулгүй байдлын талаархи сургалтад хамруулах	2008-2015	ЦССУТ, ЭМЯ ЭМШУИС
36	Эмчилгээний цус салбарт судлалын анхны мэдэгдэхүүний талаар Анагаах ухааны их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөрт тусгах	2008	ЭМЯ БСШУЯ
37	Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон эмнэл зүйн трансфузиологич, иммунологологи зэрэг шаардлагатай мэргэжлээр 6 сараас 2 жилийн хугацаагаар төрийн сургалтын сангийн санхүүжилтээр хөгжилтэй орнуудад мэргэжилтэн сургаж бэлтгэх	2008-2010	ЭМЯ БСШУЯ ЦССУТ
	Зорилт 5. Цус салбарт, судлалын үндэсний болон бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудын дэргэдэх цусны асуудал хармуцсан байгууллагын цусны хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар гадаадын болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллахыг төрөөс дэмжинэ		
38	Цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлын талаар ОХУ, БНХАУ болон бусад орны цусны асуудал хармуцсан байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх	2008-2015	ЭМЯ, ЦССУТ ДЭМБ
39	ДЭМБ, олон улсын цус салбартын холбоо, олон улсын донорын холбоо, гемофилийн холбоо зэрэг байгууллагын шугамаар зохиогдох олон улсын хурал, семинарт оролцох, мэдлэг туршлага солилцох	2008-2015	ЭМЯ, ДЭМБ
40	Эмч, эмнэлгийн дунд мэргэжилтэнд зориулсан цусны аюулгүй байдлыг хангах талаархи сургалт, семинар зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад жил бүр тусгаж байх	2008-2015	ЭМЯ, ЦССУТ
41	Цуснаар дамжих халдвараас сэргийлэх, дархлалын тогтолцоо, цусны ховор бүлгийн тархалт болон үйлдвэрлэлийн талаархи судалгааг шинжилгээний ажлыг шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр гүйцэтгүүлэх	2008-2015	ЭМЯ ЦССУТ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 112

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4, 33 дугаар зүйлийг үндэслэн Улсын Их Хурлын 2005 оны 48 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "2008 онд хувьчлах хуулийн этгээдийн жагсаалт"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2008 онд хувьчлах хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай

2. Жагсаалтад тусгагдсан хуулийн этгээдийг хувьчлах ажлыг хууль тогтоомжийн дагуу холбогдох яамдтай хамтран зохион байгуулахыг Төрийн өмчийн хороо (Д.СУГАР)-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД
САНГИЙН САЙД

С.БАЯР
Ч.УЛААН

Засгийн газрын 2008 оны 112 дугаар тогтоолын хавсралт

2008 онд хувьчлах хуулийн этгээдийн ЖАГСААЛТ

д/д	Хуулийн этгээдийн нэр	Байршил	Төрийн эзэмшлийн хувьчлах хувь, хэмжээ	Хувьчлах арга, хэлбэр, нөхцөл
1	"Монгол шуудан" ХХК	Улаанбаатар Чингэлтэй дүүрэг	33	Хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, нийт хувьцааны 67 хувийг төрийн эзэмшилд үлдээн 33 хувийг нь хөрөнгийн биржээр арилжих
2	Хөтөлийн "Цемент шохой" Төрийн өмчит хувьцаат компани	Сэлэнгэ аймаг Сайхан сум	100	Нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах
3	"Барилга архитектурын корпораци"	Улаанбаатар Хан-Уул дүүрэг	100	Зориулалтын дагуу ажиллуулах нөхцөлтэй-гээр менежментийн үр дүнг харгалзан хувьчлах
4	"Эрчим хүчний тоног төхөөрөмж, туршилт, тохируулгын үйлдвэр"	Улаанбаатар Хан-Уул дүүрэг	100	Нийтийн дуудлагын худалдаагаар хувьчлах
5	"Тарни" амралт	Сэлэнгэ аймаг Мандал сум	100	Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 113

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Замын-Үүд хилийн боомтод хил хамгаалах, гааль, цагдаа, мэргэжлийн хяналт, төмөр замын байгууллагууд болон тээврийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг зохицуулах, Засгийн газрын 2008 оны 63, Засгийн газрын 2008 оны 73 дугаар тогтоол, "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн явцад хяналт тавьж уялдуулан зохицуулах үүрэг бүхий Замын-Үүд хилийн боомт, Дорноговь аймгийн Замын-Үүд сум болон "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг хармуцсан Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийг ажиллуулах нь зүйтэй гэж үзсүгэй.

2. Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийн ажиллах журмыг хавсралтын ёсоор баталсугай.

Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч ажиллуулах тухай

3. Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийг ажиллах нөхцөлөөр хангаж, шаардагдах зардлыг холбогдох эх үүсвэрээс санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Энхболд нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Ц.МӨНХ-ОРГИЛ

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД

Засгийн газрын 2008 оны 113 дугаар
тогтоолын хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Замын-Үүдийн боомт, Дорноговь аймгийн Замын-Үүд сум болон "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийг хариуцан ажиллах Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийн /цаашид "төлөөлөгч" гэх/ үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, энэхүү журмаар зохицуулна.

1.2. Төлөөлөгч нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд даргын ангилал, зэрэглэлтэй дүйцэхүйц хангамж эдлэх бөгөөд түүний үйл ажиллагааны зардлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар баталж, зарцуулалтад нь хяналт тавина.

1.3. Шаардлагатай бол төлөөлөгч нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, бусад яам, Засгийн газрын агентлагтай тохиролцсоны үндсэн дээр холбогдох мэргэжилтийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулж болно.

1.4. Төлөөлөгч нь Засгийн газраас олгосон бүрэн эрхийн хүрээнд тушаал гаргана.

1.5. Төлөөлөгч нь зохих журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Төлөөлөгчийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

2.1. Төлөөлөгч нь Засгийн газраас олгосон бүрэн эрхийн хүрээнд Замын-Үүд боомт, Дорноговь аймгийн Замын-Үүд суманд үйл ажиллагаа явуулж байгаа дараахь байгууллагын ажлыг уялдуулан зохицуулна.

- гаалийн газар;
- цагдаагийн хэлтэс;
- хилийн отряд;
- хилийн мэргэжлийн хяналтын алба;
- гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны Замын-Үүд дэх салбар;
- тээврийн үйлчилгээний төвийн Замын-Үүд дэх салбар;
- төмөр замын Замын-Үүд зангилаа.

2.2. Дор дурдсан хууль, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг уялдуулан зохицуулна:

2.2.1. "Замын-Үүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2008 оны 63 дугаар тогтоол

2.2.2. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2008 оны 73 дугаар тогтоол

2.2.3. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль.

2.3. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүстэй холбоотой ажил, үйлчилгээ болон холбогдох яам, агентлаг, аж ахуйн нэгжийн чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг уялдуулна.

2.4. Замын-Үүдийн боомтод хийгдэх хяналт шалгалт болон тус боомт, хилийн бүсэд иргэдэд үзүүлэх үйлчилгээг олон улсын жишиг, шаардлагад нийцүүлэн шуурхай, чирэгдэлгүй, боловсронгуй болгоход шаардагдах эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтын болон санхүүжилтийн асуудлыг судлан зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

2.5. Төлөөлөгч нь "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, байнгын хяналт тавина.

2.6. Замын-Үүд сумын эрх зүйн байдлын талаар Улсын Их Хурал, Засгийн газраас гарах шийдвэрийн хэрэгжилтийг мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангуулах ажлыг зохион байгуулна.

Гурав. Төлөөлөгчийн эрх

3.1. Төлөөлөгч нь холбогдох Засгийн газрын гишүүн болон төрийн захиргааны байгууллагатай Засгийн газраас олгосон бүрэн эрхийн хүрээнд шууд харцаж ажиллана.

3.2. Орон нутгийн удирдлагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй, гагцхүү Засгийн газраас олгосон бүрэн эрхийн хүрээнд тодорхой үүрэг даалгавар, чиглэл өгнө.

3.3. Холбогдох албан тушаалтнаас шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах, хариуцсан нутаг дэвсгэрийн байгууллагын тодорхой үйл ажиллагаанд хяналт тавьж, албан тушаалтанд үүрэг даалгавар өгч болно.

3.4. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүс болон хөрөнгө оруулалттай холбоотой асуудлаар гадаадын хөрөнгө оруулагчид БНХАУ-ын Эрээн хот, Өвөр Монголын өөртөө засах орны удирдлагатай Засгийн газраас тусгайлан эрх авсан тодорхой асуудлаар шууд харилцана.

3.5. Үйл ажиллагааны чиглэл, хариуцсан ажлын талаар Засгийн газарт санал оруулж шийдвэрлүүлж болно.

Дөрөв. Төлөөлөгчийн үүрэг

4.1. Төлөөлөгч нь ажлаа Ерөнхий сайдын өмнө бүрэн хариуцна.

4.2. Төлөөлөгч нь өөрийн үйл ажиллагааны чиг үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай асуудлаар санал боловсруулж Засгийн газрын

Хэрэг эрхлэх газраар дамжуулан Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

4.3. Төлөөлөгч нь үйл ажиллагааны тайлангаа хагас, бүтэн жилээр гаргаж Засгийн газарт танилцуулна.

4.4. Төлөөлөгч нь хууль тогтоомж, Засгийн газар, Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн үүргийн биелэлтийг сар тутам гаргаж дараа сарын 5-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 115

Улаанбаатар хот

Ажлаас чөлөөлөх тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 47 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Ажлын шаардлага хангахгүй байгаа тул Үйлдвэр, худалдааны сайдын саналыг харгалзан Бат-Ундрахын Нямсүрэнг Үйлдвэр, худалдааны

яамны Төрийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 116

Улаанбаатар хот

Ажилд түр томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Доржсүрэнхорлоогийн Хүрэлбаатарыг Үйлдвэр, худалдааны яамны Төрийн

нарийн бичгийн даргаар түр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 03 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 120

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Соёлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Олон улсын хэмжээнд зохиогддог соёл, урлагийн их наадам, уралдаан, үзэсгэлэн, номын

яармагт оролцож, онцгой амжилт гаргасан соёлын ажилтан, уран бүтээлчдэд мөнгөн шагнал олгох журам"-ыг 1 дүгээр, "Онцгой амжилт гаргасан уран бүтээлчдэд олгох мөнгөн шагналын хэмжээ"-г 2 дугаар, "Олон улсын хэмжээнд зохиогддог соёл, урлагийн их наадам, уралдаан, үзэсгэлэн, номын

яармагийн жагсаалт"-ыг 3 дугаар, "Олон улсын хэмжээнд зохиогддог өсвөрийн уран бүтээлчдийн соёл, урлагийн их наадам, уралдааны жагсаалт"-ыг 4 дүгээр хавсралтын ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам шинэчлэн батлах тухай" Засгийн газрын

2005 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 165 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД** **Н.БОЛОРМАА**

**Засгийн газрын 2008 оны 120 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт**

**ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ЗОХИОГДДОГ СОЁЛ,
УРЛАГИЙН ИХ НААДАМ, УРАЛДААН, ҮЗЭСГЭЛЭН,
НОМЫН ЯАРМАГТ ОРОЛЦОЖ ОНЦГОЙ АМЖИЛТ ГАРГАСАН
СОЁЛЫН АЖИЛТАН, УРАН БҮТЭЭЛЧДЭД МӨНГӨН ШАГНАЛ
ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь соёл, урлагийн бүтээл, соёлын ажилтан, уран бүтээлчдийн оюуны болон ур чадварын үнэлэмжийг дээшлүүлж, соёл, урлагийн салбарт өндөр амжилт гаргах идэвхи сонирхлыг өрнүүлэх, улмаар дэлхийн хэмжээнд өөрийн орны урлагийн нэр хүнд, байр суурийг дээшлүүлэхэд оршино.

1.2. Олон улсын хэмжээнд зохиогддог соёл, урлагийн их наадам, уралдаан, үзэсгэлэн, номын яармаг /цаашид их наадам, уралдаан, үзэсгэлэн, номын яармаг гэх/-т тэргүүн байр /гран при/, нэгдүгээр байр /алтан медаль/, хоёрдугаар байр /мөнгөн медаль/, гуравдугаар байр /хүрэл медаль/-нд шалгарсан уран бүтээлчдийг шагнахад энэхүү журмыг баримтална.

Хоёр. Шагнал олгох зарчим

2.1. Их наадам, уралдаан, үзэсгэлэн, номын яармагт оролцож онцгой амжилт гаргасан уран бүтээлчдэд мөнгөн шагнал олгохдоо их наадам, уралдаан, үзэсгэлэн, номын яармагийн албан ёсны урилга, тэмдэглэл, байр эзэлсэн тухай батламж (гэрчилгээ, диплом, үнэмлэхний албан ёсны орчуулга), соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал зэргийг үндэслэн шагнал олгох шийдвэрийг Засгийн газар гаргана.

2.2. Соёлын ажилтан, уран бүтээлчид их наадам, уралдаан, үзэсгэлэн, номын яармагт оролцож онцгой амжилт үзүүлсэн тухайгаа холбогдох баримт бичгийн хамт соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв

байгууллагад их наадам, уралдаан, үзэсгэлэн, номын яармаг дууссанаас хойш 90 хоногийн дотор ирүүлнэ.

2.3. Уран бүтээлчийн мөнгөн шагналаас соёлын ажилтан, сургагч багш, менежер, бүтээлийн зохиогч болон харьяалагдаж байгаа байгууллагад нь тодорхой хувь ногдуулах асуудлыг гэрээгээр зохицуулна. Гэрээний үлгэрчилсэн загварыг Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

2.4. Их наадам, уралдаан, үзэсгэлэн, номын яармагт 2-4 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон тохиолдолд гишүүн тус бүрт энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан мөнгөн шагналын 25 хувьтай тэнцэх мөнгөн шагнал; 5 болон түүнээс дээш хүний бүрэлдэхүүнтэй оролцсон тохиолдолд хамтлагт нь 2 дугаар хавсралтын дагуу мөнгөн шагналыг олгоно.

2.5. Уран бүтээлч жилд нэг уран бүтээлээр 2-оос дээш удаа их наадам, уралдаан, үзэсгэлэн, номын яармагт оролцож, амжилт гаргасан тохиолдолд уран бүтээлчийн үзүүлсэн хамгийн өндөр амжилтаар мөнгөн шагналыг нэг удаа олгоно.

2.6. Мөнгөн шагналд зориулах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган, Соёл, урлагийг хөгжүүлэх сангаар дамжуулан санхүүжүүлнэ.

2.7. Мөнгөн шагнал олгоход зориулсан хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно.

Засгийн газрын 2008 оны 120 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

ОНЦГОЙ АМЖИЛТ ГАРГАСАН УРАН БҮТЭЭЛЧДЭД ОЛГОХ МӨНГӨН ШАГНАЛЫН ХЭМЖЭЭ

1. Дуу, хөгжим, бүжиг, циркийн төрлөөр шалгарсан уран бүтээлчдэд олгох мөнгөн шагнал:

№	Ангилал	Төрөл	Байр	Мөнгөн шагналын хэмжээ /сая төгрөг/
1	"А"	Дуу, хөгжим, бүжиг	Тэргүүн шагнал /гран при/	80.0
			Нэгдүгээр байр /алтан медаль/	65.0
			Хоёрдугаар байр /мөнгөн медаль/	52.0
			Гуравдугаар байр /хүрэл медаль/	40.0
		Цирк	Тэргүүн шагнал /гран при/	65.0
			Нэгдүгээр байр /алтан медаль/	52.0
			Хоёрдугаар байр /мөнгөн медаль/	40.0
			Гуравдугаар байр /хүрэл медаль/	34.0
2	"Б"	Дуу, хөгжим, бүжиг	Тэргүүн шагнал /гран при/	34.0
			Нэгдүгээр байр /алтан медаль/	29.0
			Хоёрдугаар байр /мөнгөн медаль/	24.0
			Гуравдугаар байр /хүрэл медаль/	19.0
		Цирк	Тэргүүн шагнал /гран при/	24.0
			Нэгдүгээр байр /алтан медаль/	21.0
			Хоёрдугаар байр /мөнгөн медаль/	19.0
			Гуравдугаар байр /хүрэл медаль/	16.0

2. Кино театр, дүрслэх урлаг, номын яармаг, утга зохиолын төрлөөр шалгарсан уран бүтээлчдэд олгох мөнгөн шагнал

№	Ангилал	Төрөл	Байр	Мөнгөн шагналын хэмжээ /сая төгрөг/
1	"А"	Кино	Тэргүүн шагнал	65.0
		Театр	Тэргүүн шагнал	65.0
		Дүрслэх урлаг	Тэргүүн шагнал	65.0
		Номын яармаг	Тэргүүн шагнал	65.0
		Утга зохиол	Тэргүүн шагнал	65.0
2	"Б"	Кино	Тэргүүн шагнал	34.0
		Театр	Тэргүүн шагнал	24.0
		Дүрслэх урлаг	Тэргүүн шагнал	24.0
		Номын яармаг	Тэргүүн шагнал	24.0
		Утга зохиол	Тэргүүн шагнал	24.0

3. Өсвөрийн уран бүтээлчдэд олгох мөнгөн шагнал

№	Ангилал	Төрөл	Байр	Мөнгөн шагналын хэмжээ /сая.төгрөг/
1	"А" зэрэглэл	Дуу, хөгжим, бүжиг	Тэргүүн шагнал /гран при/	34.0
			Нэгдүгээр байр /алтан медаль/	29.0
			Хоёрдугаар байр /мөнгөн медаль/	24.0
			Гуравдугаар байр /хүрэл медаль/	19.0
		Цирк	Тэргүүн шагнал /гран при/	24.0
			Нэгдүгээр байр /алтан медаль/	19.0
			Хоёрдугаар байр /мөнгөн медаль/	14.0
			Гуравдугаар байр /хүрэл медаль/	9.0
2	"Б" зэрэглэл	Дуу, хөгжим, бүжиг	Тэргүүн шагнал /гран при/	24.0
			Нэгдүгээр байр /алтан медаль/	19.0
			Хоёрдугаар байр /мөнгөн медаль/	14.0
			Гуравдугаар байр /хүрэл медаль/	9.0
		Цирк	Тэргүүн шагнал /гран при/	19.0
			Нэгдүгээр байр /алтан медаль/	14.0
			Хоёрдугаар байр /мөнгөн медаль/	9.0
			Гуравдугаар байр /хүрэл медаль/	4.0

Засгийн газрын 2008 оны 120 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ЗОХИОГДДОГ СОЁЛ, УРЛАГИЙН ИХ НААДАМ, УРАЛДААН, ҮЗЭСГЭЛЭН, НОМЫН ЯАРМАГИЙН ЖАГСААЛТ

Ангилал	Төрөл	Давтамж
"А"	Бүжгэн жүжиг	
	1. АНУ-д зохиогддог Нью-Йоркийн олон улсын сонгодог бүжгийн уралдаан	4 жил тутам
	2. ОХУ-ын Москва хотод зохиогддог Ю.Н.Григоровичийн нэрэмжит олон улсын сонгодог бүжгийн уралдаан	4 жил тутам
	3. Бүгд Найрамдах Франц Улсын Парис хотод зохиогддог олон улсын сонгодог бүжгийн уралдаан	4 жил тутам
	4. АНУ-д зохиогддог Жаксоны олон улсын сонгодог бүжгийн уралдаан	4 жил тутам
	5. ОХУ-ын Пермь хотод зохиогддог олон улсын сонгодог бүжгийн уралдаан	2 жил тутам
	6. БНХАУ-ын Шанхай хотод зохиогддог олон улсын сонгодог бүжгийн уралдаан	4 жил тутам

	<u>Дуу, хөгжим</u>	
	1. ОХУ-ын Москва хотод зохиогддог П.И.Чайковскийн нэрэмжит уралдаан	4 жил тутам
	2. Бүгд Найрамдах Итали Улсын Буссето хотод зохиогддог "Бердианы дуу хоолой" олон улсын дуурийн дуулаачдын уралдаан	Жил тутам
	3. ЮНЕСКО-гоос зохион байгуулдаг хөгжмийн зохиолчдын уралдаан	2 жил тутам
	4. Бүгд Найрамдах Польш Улсад зохиогддог Ф.Шопены нэрэмжит төгөлдөр хуурчдын уралдаан	Жил тутам
	5. Бүгд Найрамдах Австри Улсын Зайльцбург хотод зохиогддог А.Моцартын нэрэмжит уралдаан	3 жил тутам
	6. Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотод зохиогддог олон улсын хөгжимчдийн наадам	2 жил тутам
	7. БНХАУ-ын Соёлын яамнаас зохион байгуулдаг олон улсын дуу, хөгжмийн уралдаан (төгөлдөр хуур, хийл, дуулаач)	2 жил тутам
	8. АНУ-ын Миссисурри муж улсад зохиогддог олон улсын төгөлдөр хуурчдын уралдаан	2 жил тутам
	9. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Цикау хотод зохиогддог Р.Шуманы нэрэмжит олон улсын төгөлдөр хуурчдын уралдаан	4 жил тутам
	10. ОХУ-ын Санкт-Петербург хотод зохиогддог Б.К.Прокофьевын нэрэмжит уралдаан	4 жил тутам
	<u>Бүжгэн жүжиг</u>	
	1. Япон Улсад зохиогддог Ази, Номхон далайн орнуудын олон улсын сонгодог бүжгийн уралдаан	2 жил тутам
	2. Бүгд Найрамдах Болгар Улсын Варна хотод зохиогддог олон улсын сонгодог бүжгийн уралдаан	4 жил тутам
"Б"	<u>Дуу, хөгжим</u>	
	1. ОХУ-д зохиогддог М.И.Глинкийн нэрэмжит дуурийн дуулаачдын уралдаан	2 жил тутам
	2. ОХУ-д зохиогддог Римский-Корсаковын нэрэмжит дуурийн дуулаачдын уралдаан	2 жил тутам
	4. АНУ-д зохиогддог Барток Кабалевский- Прокофьевын нэрэмжит төгөлдөр хуурчдын уралдаан	Жил тутам
"А"	<u>Цирк</u>	
	1. Монакогийн Вант Улсын Монте Карлод зохиогддог дэлхийн циркчдийн их наадам	2 жил тутам
	2. БНХАУ-ын Ухань, Учо хотуудад зохиогддог олон улсын циркчдийн уралдаан	Жил тутам
	<u>Кино</u>	
	1. АНУ-ын Кино урлагийн академиас зохион байгуулдаг Оскарын кино их наадам	Жил тутам
	2. Бүгд Найрамдах Франц Улсад зохиогддог Каннын кино их наадам	Жил тутам
	3. Бүгд Найрамдах Итали Улсад зохиогддог Венецийн кино наадам	Жил тутам
	4. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад зохиогддог Берлинару кино их наадам	Жил тутам
	<u>Театр</u>	
	1. ЮНЕСКО-гийн III-гаас зохион явуулдаг олон улсын театрын фестиваль	Жил тутам
	2. ОХУ-д зохиогддог А.П.Чеховын нэрэмжит олон улсын театрын фестиваль	Жил тутам
	<u>Дүрслэх урлаг</u>	
1. Бүгд Найрамдах Солонгос Улсад зохиогддог Кванжоу орчин үеийн шинэ урлагийн олон улсын биенналь	2 жил тутам	
2. Бүгд Найрамдах Итали Улсад зохиогддог Венецийн биенналь	2 жил тутам	
3. Япон Улсад зохиогддог Экохамагийн треминаль	3 жил тутам	
4. БНХАУ-д зохиогддог Бээжингийн биенналь	2 жил тутам	
<u>Утга зохиол</u>		
1. Дэлхийн утга зохиолын Нобелийн шагнал	Жил тутам	

	2. АНУ-ын Оклахомагийн их сургуулийн Ньюстант шагнал	Жил тутам
	3. Шведийн Вант Улсын Засгийн газраас зохион байгуулдаг Астрид Линдгериий нэрэмжит хүүхдэд зориулсан утга зохиолын уралдаан	Жил тутам
"Б"	Театр	
	1. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад зохиогддог /Эдинбург/ олон улсын театрын уралдаан	4 жил тутам
	2. ОХУ-д зохиогддог "Алтан маск" театрын уралдаан	Жил тутам
	3. Япон Улсад зохиогддог Токиогийн олон улсын театрын наадам	2 жил тутам
	Цирк	
	1. ОХУ-ын Санкт-Петербург хотод зохиогддог циркчдийн олон улсын уралдаан	Жил тутам
	2. Шведийн Вант Улсад зохиогддог Хатан хааны нэрэмжит циркчдийн олон улсын уралдаан	Жил тутам
	3. Бүгд Найрамдах Унгар Улсын Будапешт хотод зохиогддог циркчдийн уралдаан	Жил тутам
	4. Швейцарийн Холбооны Улсын Цюрих хотод зохиогддог циркчдийн уралдаан	Жил тутам
	Кино	
	1. Япон Улсын Токио хотод зохиогддог кино наадам	2 жил тутам
	2. Япон Улсын Ямагата хотод зохиогддог баримтат киноны их наадам	2 жил тутам
	3. ОХУ-д зохиогддог Москвагийн киноны их наадам	2 жил тутам
	4. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад зохиогддог Берлиний баримтат киноны их наадам	3 жил тутам
	5. Япон Улсын Фукуокад зохиогддог кино наадам	Жил тутам
	Хүүхэлдэйн урлаг	
	1. Азийн орнуудын хүүхэлдэйн театруудын их наадам	2 жил тутам
	Дүрслэх урлаг	
	1. Япон Улсад ЮНЕСКО, Японы Азийн соёлын төвөөс зохион байгуулдаг "Noma" Ази, Номхон далайн орнуудын олон улсын хүүхдийн номын зургийн уралдаан	2 жил тутам
	2. Бүгд Найрамдах Словак Улсын Братислав хотод зохиогддог "Алтан алим" хүүхдийн номын зургийн олон улсын уралдаан	2 жил тутам
	Номын яармаг	
	1. Холбооны Бүгд найрамдах Герман Улсын Франкфурт хотод зохиогддог олон улсын номын яармаг	Жил тутам
	2. Бүгд Найрамдах Итали Улсын Венец хотод зохиогддог "Номын төслийн уралдаан"	Жил тутам
Утга зохиол		
1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад зохиогддог Георг Бюхнерийн нэрэмжит олон улсын уралдаан	Жил тутам	
2. Ханс Кристиан Андерсены нэрэмжит хүүхдэд зориулсан утга зохиолын уралдаан	Жил тутам	

Засгийн газрын 2008 оны 120 дугаар
тогтоолын 4 дүгээр хавсралт

ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ЗОХИОГДДОГ ӨСВӨРИЙН УРАН БҮТЭЭЛЧДИЙН ИХ НААДАМ, УРАЛДААНЫ ЖАГСААЛТ

Ангилал	Төрөл	Давтамж
"А"	Дуу, хөгжим	
	1. ОХУ-д зохион байгуулагддаг П.И.Чайковскийн нэрэмжит залуу хөгжимчдийн уралдаан (төгөлдөр хуур, хийл, виолончель)	2 жил тутам
"Б"	1. Бүгд Найрамдах Франц Улсад зохиогддог М.Магины нэрэмжит олон улсын өсвөрийн төгөлдөр хуурчдын уралдаан	Жил тутам
	2. Бүгд Найрамдах Чех Улсад зохиогддог Косианы нэрэмжит олон улсын залуу хийлчдийн уралдаан	жил тутам
"А"	Цирк	
	1. Монакогийн Вант Улсын Монте-Карлод зохиогддог дэлхийн өсвөрийн циркчдийн их наадам	Жил тутам
	2. Бүгд Найрамдах Франц Улсын Парис хотод зохиогддог өсвөрийн циркчдийн уралдаан	Жил тутам
"Б"	1. БНХАУ-ын Ухань, Учо хотуудад зохиогддог олон улсын өсвөрийн циркчдийн уралдаан	Жил тутам

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

 2008 оны 04 дүгээр
сарын 02-ны өдөр

Дугаар 124

 Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Газрын тухай хуулийн 29.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгжид үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар эзэмшүүлэх газрын дээд хэмжээ" гэсэн 8 дугаар хавсралтын 1 дэх заалтын "3000 га" гэснийг "20000 га" гэж, мөн хавсралтын 2 дахь заалтын "50 га" гэснийг "200 га" гэж тус тус өөрчилсүгэй.

2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Цолмон, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	С.БАЯР
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	Ц.ЦОЛМОН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД	Ц.ГАНХУЯГ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэл хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 5